

# Гарчиг

<b>ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ</b>	<b>3</b>
<b>ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ</b>	<b>4</b>
<b>МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ</b>	<b>7</b>
Монгол улсын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	7
Дотоодын нийт бүтээгдэхүүн	8
Улсын нэгдсэн төсөв	10
Монгөний зах зээл, банк санхүүгийн систем	11
<b>ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТ</b>	<b>14</b>
<b>БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ</b>	<b>15</b>
<b>ӨНГӨРӨГЧ ОНД ГОЛОМТ БАНК</b>	<b>18</b>
Бизнесийн бус үйл ажиллагаа	18
Хүний нөөцийн тайлан	18
Мэдээллийн технологийн тайлан	20
Нийгэмд чиглэсэн арга хэмжээ	21
Бизнесийн үйл ажиллагаа	22
Салбар, тооцооны төвцүд	22
Цахим банк	24
Харилцах, хадгаламжийн цүлчилгээ	24
Төлбөрийн картын цүлчилгээ	25
Зээлийн цүлчилгээ	26
Гадаад харилцаа, хамтын ажиллагаа	29
Санхүүгийн үр дүнгийн үзүүлэлтүүд	30
Төсөв төлөвлөгөө, санхүүгийн зорилтуудын биелэлт	30
Активын хөдлөл өөрчлөлт	31
Эх цэсвэрийн хөдлөл өөрчлөлт	32
Ашигт ажиллагаа	33
Эрсдэлийн удирдлага	33
Зээлийн эрсдэл	34
Зах зээлийн эрсдэл	35
Үйл ажиллагааны эрсдэл	36
<b>БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ</b>	<b>37</b>
<b>ГОЛОМТ БАНКНЫ ТӨВ, САЛБАРУУДЫН ХАЯГ БАЙРШИЛ</b>	<b>38</b>
<b>ХӨНДЛҮӨНГИЙН ХЯНАЛТЫН ТАЙЛАН</b>	<b>39</b>



# ТУЗ-ийн Даргын Илгээлт



Эрхэм хүндэт хувь нийлэгчид, харилцагчид, бизнесийн түнш, Голомт банкны нийт ажилтнууд та бүхний итгэл найдвар, хамтын ажиллагаанд талархаж буйгаа илэрхийлээд цаашдын бизнес ажил хэрэгт тань өндөр амжилт хүсэн ерөө.

Бидний хамтын ажиллагаа улам өргөжин хөгжиж, та бүхний амьдрал цэцэглэн дэвжих болтугай.



Л. БОЛДХУЯГ  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

# Ерөнхий Захирлын Мэндчилгээ

Эрхэм хувь нийлүүлэгч, харилцагч, хамтран ажиллагсад та бүхэндээ төлөвлөгөөт зорилтоо биелүүлж өсч хөгжсөн, дэлхий нийтийн жишгээс суралцаж ахиж дэвшисэн, өргөжин тэлж харилцагчиддаа илүү их ойртсон, амжилт бүтээлээр арвин бас нэгэн санхүүгийн жилийнхээ тайланг толилуулж байгаадаа миний бие туйлын баяртай байна.

2006 он Голомт банкны хувьд өнгөрсөн арван жилийнхээ амжилтыг бататгасан, угтан ирж буй олон арван жилүүдийн амжилтын хуудсыг урамтайгаар эхлүүлсэн сайхан жил болж өнгөрлөө. Өнгөрөгч онд бид МУ-ын банк санхүүгийн зах зээл дэх тэргүүлэх байр сууриа хадгалан, харилцагчиддаа барих бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ нэр төрлийг олшуулах, сайжруулах, өргөжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр ирсэн ба банкны нийт актив өмнөх оныхоос 29 хувиар өсч 352 тэрбум төгрөгт хүрсэн, улсын төсөвт 1.3 тэрбум төгрөгийн татвар төлж, 2.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан амжилтаар шинэ санхүүгийн жилтэй золгож байна.

Банкны үйл ажиллагааны нэр төрөл, хамрах хүрээ өргөжих, харилцагчдын тоо болон бизнесийн чадавхи нэмэгдэхийн хэрээр банкны эрдэл даах чадварыг сайжруулах, харилцагчиддаа илүү өргөн хүрээнд, өндөр түвшинд үйлчлэх зайлшгүй шаардлага тавигдаж, энэ үүднээс банкны хувь нийлүүлэгчид дүрмийн сангаа 8.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Ингэснээр банкны өөрийн хөрөнгийн хэмжээ тайлант оны эцэст 35 тэрбум төгрөгт хүрч, харилцагчид банкны олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэгэн зэрэг авах, Голомт банкаар урт хугацаанд тогтвортой үйлчилгүүлэх боломж улам бур нээлттэй болж, банкны гадаад харилцаа өргөжлөө.

Бид ард түмний эрэлт хэрэгцээг судлан тэдэнд хэрэгцээтэй байгаа банкны бүтээгдэхүүнийг олж илрүүлэх, судалж нэвтрүүлэх болон хөгжилтэй орнуудын застийн газар, олон улсын байгууллагуудын зүгээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт идэвхитэй оролцоо замаар банкны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцагчдад аль болох ойртуулахад ихээхэн анхаарч ажилладаг. Тухайлбал,

өнгөрөгч онд бид жижиг дунд бизнесийг (ЖДБ) дэмжих зорилгоор энэ чиглэлд голлон ажиллах зээлийн төвийг шинээр байтууллаа. Уг төв нь ЖДБ-ийн зээлийг богино хугацаанд шийдвэрлэх, зээлийн нөхцлийг харилцагчдын эрэлт хэрэгцээнд ойртуулж, богино хугацаанд өөрчлөн сайжруулах боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба үүний дунд ЖДБ-ийн зээлийн нийт багц 41 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 73 хувиар нэмэгдлээ. Мөн Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкны санхүүжилтээр Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлэх “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах” зорилго бүхий урт хугацаат зээлийн төсөлд оролцох 6 банкны нэгээр шалгаран, 3-10 жилийн хугацаатай, 10,000-600,000 ам долларын зээлийг жилийн 9,93 /валют/-11,46/төгрөг/ хувийн хүүтэйгээр олгох боломжтой болов. Түүнчлэн, Нидерландын застийн газрын санхүүжилтээр эрчим хүчиний хэмнэлттэй техник тоног төхөөрөмжийг ашиглаж эрчим хүчиний үр ашигийг дээшлүүлэх, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, цэвэр үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой “Ногоон зээл” -г олгох гэрээнд гарын үсэг зурсанаар энэ чиглэлийн бизнес эрхлэгчдэд 3 жилийн хугацаатай, 30-40 сая төгрөгийн зээлийг жилийн 16 хувийн хүүтэйгээр олгож эхлээд байна.

МУ-ын банк санхүүгийн зах зээл шинэ бүтээгдэхүүн, шинэ технологитой хамт тасралтгүй хөгжсөөр байна. Голомт банк ч энэ хөгжлийн тэргүүн эгнээнд явж, харилцагчиддаа олон улсын банк санхүүгийн зах зээлийн жишиг, стандартад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг санал болгох, төлбөр тооцоог түргэн шуурхай, найдвартай гүйцэтгэх, автоматжуулах тал дээр нэлээд ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Энэ зорилтын хүрээнд өөрөө өөртөө үйлчлэх бэлэн мөнгөний автомат машинуудыг Улаанбаатар хотын гол цэгүүдэд суурилуулан үйлчилгээнд нэвтрүүлсэний дээр картын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, хэд хэдэн төрлийн шинэ картыг зах зээлд гаргалаа. Тухайлбал, МИАТ ХК-тай хамтран MIAT Mileage Кобренд карт, Эйрнэтворк ХК-тай хамтран Airnetwork Mileage Алтан карт, Италияны Турин хотноо болсон Олимпийн олимпод Монгол



Банкны нийт актив өмнөх  
оныхоос 29 хувиар өсч 352 тэрбум  
төгрөгт хүрсэн, улсын төсөвт  
1,3 тэрбум төгрөгийн татвар төлж,  
2,5 тэрбум төгрөгийн цэвэр  
ашигтай ажилласан амжилтаар  
нэгэн санхүүгийн жилийг үдлээ.

**Д.БАЯСГАЛАН, ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ**

улсаас оролцсон баг тамирчдаа дэмжин Torino-2006 Виза картуудыг зах зээлд гаргасан зэргийг энд дурдахад таатай байна. Ингэснээр, тайлант онд 66 мянган карт борлуулж, нийт карт эзэмшигчдийн тоо 209 мянгад хүрч, картын хэрэглээ, зах зээл илэрхий өсөн нэмэгдсээр байна.

Дээрх бүх үйл ажиллагааны үр дүнд банкны санхүүгийн үзүүлэлтүүдэд ахиц гарч, хүүгийн болон хүүгийн бус орлогын нийт хэмжээ 31.7 тэрбум төгрөгт хүрч банкны ашигт ажиллагаа нэмэгдлээ. Ийнхүү ашигт ажиллагаа нэмэгдэж, үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр банкны эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагааны бүхий л түвшинд сайжруулах шаардлага тавигдаг нь банкны менежментийн үндсэн зарчим юм. Иймд өнгөрөгч онд бид банкны эрсдэлийн удирдлагыг сайжруулах, бэхжүүлэх чиглэлд дорвitoй ажлуудыг хийж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандaa Базелийн Хорооны аргачлал, зарчмуудыг нэвтрүүлэн, шинэлэг арга барил, туршлагуудыг хэрэгжүүлж эхлээд байна. Ингэснээр, банкны өсөлтийг цогцоор нь удирдах, хэмжих, хянах боломж бүрдсэн ба бид энэ чиглэлд илүү өргөн хүрээтэй ажлуудыг хийж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог илүү боловсронгуй болгох чиглэлээр нэлээд ажлуудыг төлөвлөн хийж эхлээд байна.

Банк, санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр харилцагчдын хямд үнээс илүүтэйгээр, итгэл найдвар бүхий соёлтой үйлчилгээг эрхэмлэх байдал нь нэмэгдсээр байна. Бид өнгөрсөн бүхий л хугацааны туршид харилцагчийг тэргүүн эгнээнд тавьсаар ирсэн ба 2006 онд Картын төв, Хувийн Банкны Албаны үйлчилгээний орчинг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн бухэлд нь өөрчиллөө. Ингэснээр, эдгээр нэгжүүд хамгийн шинэлэг загвар дизайн бүхий байранд үйл ажиллагаагаа явуулж харилцагчиддаа ганцаарчилсан болон тусгайлсан банкны үйлчилгээг үзүүлж байгаа нь ихээхэн талархал хүлээж байна.

Ирж буй 2007 он Голомт банкны хувьд амжилтын түүхэн хуудсаа нэгээр нэмэх хөгжил, дэвшилийн жил байна гэдэгт банкны нийт хамт олон итгэлтэй байна. Бид ирэх онд харилцагчидтай тогтоосон харилцаа, холбоогоо улам бэхжүүлэх, бататгах, шинэ зах зээлийг нээн илрүүлж, түүнд хүрч үйлчлэх, жижиг дунд бизнес эрхлэгчид, иргэдэд зориулсан зээлийг түлхүү хөгжүүлэх болон мэдээллийн технологийн дэвшилтэй шийдэл, түгээлтийн боломжит бүхий л сувгуудаар харилцагчдад түргэн шуурхай үйлчлэх нэхцлийг бүрдүүлэх зэрэгт анхаарч ажиллах болно. Эдгээрээс бид эн тэргүүнд банкны ажилтны оролцоогүйгээр 24 цагийн туршид банкны үйлчилгээг авах боломжтой SELF banking буюу өөртөө үйлчлэх цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх, мобайл банк буюу гар утаснаасаа банкны үйлчилгээг авах боломжийг өргөжүүлэх, харилцах хадгаламжийг картжуулах, интернетээр данс нээх, бүх төрлийн гүйлгээ хийх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Эцэст нь, энэ бүх өсөлт дэвшил, амжилтыг хамтран бий болгосон хувь нийлүүлэгчид, харилцагчид, хамтран ажиллагсад, бизнесийн түншүүд болон банкныхаа нийт хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бидний хамтын ажиллагаа улиран өнгөрөх он цагийн тоогоор илүү өргөн хүрээтэй, гүн агуулгатай болон хөгжиж, улс орон маань хөгжин цэцэглэх болтугай. Голомт банктай хамт гэрэл, гэгээтэй, өөдрөг тэнүүн шинэ өдрийдийг утгаж буй та бүхэнд сайн сайхныг хүсэн өрөө.



Д. БАЯСГАЛАН  
Ерөнхий Захирал

# Монгол Улсын Нийгэм Эдийн Засгийн Байдал

## МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2000	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Макро эдийн засгийн зорилтот үзүүлэлтүүд</b>							
ДНБ-ий өсөлт /хувиар/	1.1	1.1	4.0	5.6	10.7	7.0	8.4
Хөдөө аж ахуй	- 15.9	- 18.3	- 12.5	4.9	17.7	9.6	9.7
Үйлдвэр	0.7	15.4	4.1	5.9	14.5	1.2	7.9
Үйлчилгээ	15.3	6.2	11.8	6.6	6.6	8.3	8.1
Нэг хүнд ноогдох ДНБ /мян. төгрөгөөр/	426.2	460.1	504.6	586.9	758.7	888.4	1 222.9
Нэг хүнд ноогдох ДНБ /ам.доллар/	396.0	419.1	454.5	511.9	640.1	737.0	1 036.8
Хэрэглээний үнийн өөрчлөлт, оны эцэст	8.1	8.0	1.6	4.7	11.0	9.5	6.0
Нийт мөнгөний /М2/ өөрчлөлт	17.6	27.9	42.0	49.6	20.4	38.1	34.8
<b>Бодлогын үзүүлэлтүүд</b>							
<b>Төсөв, тэрбум төгрөг</b>							
Нийт орлого ба тусlamжийн дүн	351.0	439.3	477.1	553.9	713.1	837.9	1 353.2
Ургал орлого	346.2	430.0	469.8	545.2	706.3	832.6	1 346.8
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	429.7	489.9	550.5	615.8	752.5	764.6	1 228.7
Үүнээс: Хөрөнгийн зардал	52.1	59.1	68.1	90.5	104.9	89.8	177.5
Ургал зарлага	314.1	366.8	415.3	434.8	538.7	600.3	978.5
Ургал тэнцэл	32.1	63.1	54.4	110.4	167.6	232.3	368.4
Нийт тэнцэл	- 78.7	- 50.6	- 73.4	- 61.9	- 39.4	73.3	124.5
<b>Төсөв, ДНБ-д эзлэх хувь</b>							
Нийт орлого ба тусlamжийн дүн	34.5	39.4	38.4	37.9	37.3	37.0	42.7
Ургал орлого	34.0	38.5	37.9	37.3	37.0	36.7	42.5
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	42.2	43.9	44.4	42.1	39.4	33.7	38.7
Үүнээс: Хөрөнгийн зардал	5.1	5.3	5.5	6.2	5.5	4.0	5.6
Ургал зарлага	30.8	32.9	33.5	29.8	28.2	26.5	30.8
Ургал тэнцэл	3.2	5.7	4.4	7.6	8.8	10.2	11.6
Нийт тэнцэл	- 7.7	- 4.5	- 5.9	- 4.2	- 2.1	3.2	3.9
<b>Гадаад худалдааны тэнцэл /сая ам.доллар/</b>							
-ДНБ-ий хувь	- 140.1	- 170.0	- 228.9	- 185.2	- 151.5	- 119.4	39.6
Экспорт	-14.8	-16.7	-20.5	-14.5	-9.4	-6.3	1.5
өсөлт, хувиар	535.8	523.2	523.9	615.9	869.7	1 064.9	1 528.8
Импорт /төлбөрийн тэнцлийн тоо/	17.9	- 2.4	0.1	17.6	41.2	22.4	43.6
өсөлт, хувиар	675.9	693.1	752.8	801.0	1 021.2	1 184.3	1 489.2
Гадаад валютын цэвэр нөөц (сая ам.дол)	19.1	2.6	8.6	6.4	27.5	16.0	25.7
-импортын 7 хоногоор	140.7	160.1	225.9	129.0	163.6	298.0	687.3
Суурь үзүүлэлтүүд	10.8	12.0	15.6	8.4	8.3	13.1	24.0
ДНБ оны үнээр, /тэрбум.төг/	1 018.9	1 115.6	1 240.8	1 461.2	1 910.9	2 266.5	3 172.4
Валютын ханш жил.эцэст /1ам дол=төг/	1 097.0	1 102.0	1 125.0	1 168.0	1 209.0	1 221.0	1 165.0
Валютын ханш жил.дунд /1ам дол=төг/	1 076.4	1 097.7	1 110.3	1 146.5	1 185.3	1 205.3	1 179.5
Хүн амын дундаж тоо, мянган хүнээр	2 390.5	2 425.0	2 459.0	2 489.7	2 518.6	2 551.3	2 594.1
Ажилгүйдлийн түвшин	4.6	4.6	3.4	3.5	3.6	3.3	3.2
ДНБ сая ам.доллараар	946.6	1 016.3	1 117.5	1 274.5	1 612.1	1 880.4	2 689.6

## ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

ДНБ-д салбаруудын эзлэх хувь	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнэ, тэрбум)	1 018.9	1 115.6	1 240.8	1 461.2	1 910.9	2 266.5	3 172.4
Үүнд: ХАА, ой аж ахуй, ан агнуур	29%	25%	21%	20%	21%	22%	19%
Уул уурхай, олборлох үйлдвэр	12%	9%	10%	13%	19%	20%	30%
Боловсруулах үйлдвэр	6%	8%	6%	6%	5%	4%	6%
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	2%	3%	4%	3%	3%	3%	3%
Барилга	2%	2%	2%	3%	2%	2%	2%
Бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	24%	27%	28%	26%	24%	25%	19%
Тээвэр, агуулахын аж ахуй холбоо	11%	13%	15%	14%	13%	12%	11%
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	2%	3%	3%	4%	4%	4%	3%
Бусад	11%	10%	11%	10%	9%	7%	8%

Монгол улсын Дотоодын нийт бүтээгдхүүн 2006 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх онтой харьцуулахад 8,4. % -иар буюу 113 тэрбум төгрөгөөр өсч оны үнээр 3,2 триллион төгрөгт хүрэв. Ийнхүү эдийн засгийн өсөлт өмнөх оныхаас 1,4 пунктээр сайжирсан үзүүлэлттэй байна. ДНБ-ний 8.4 хувийн өсөлтийн 2 пункт нь ХАА, 2 пункт нь үйлдвэрлэл, 4.4 пункт нь үйлчилгээний салбарт тус тус бүтээгджээ.

Эдийн засгийн өсөлтөнд экспортын голлох бүтээгдэхүүн болох зэс, алтны дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, цаг агаарын тааламжтай нөхцөлөөс үүдэлтэй хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл, Төсвийн татварын орлогын өсөлт, гадаадын зээлд сууринласан төсвийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт, Хүн амын, цалингийн болон ажиллах хүчиний өсөлт, гадаадаас ирэх мөнгөн гүйвуулгын өсөлтийг дагасан өрхийн хэрэглээний өсөлт, аж ахуйн нэгжүүдийн бий болгосон хуримтлал, банкны системээс олгосон зээл, гадаадын хөрөнгө оруулалт дээр тулгуурласан аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын өсөлт, тухайлбал хөдөө аж ахуй, үйлчилгээ, уул уурхай, барилга, холбоо тээврийн салбарт хөрөнгө оруулалт эрс өссөн нь нөлөөлсөн байна.

**Уул уурхай, олборлох цүлдвэрлэл.** Уул уурхай, олборлох цүлдвэрлэлийн салбар нь Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг бөгөөд 2006 онд ДНБ-ий 30 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 71,9 хувь, экспортын бүтээгдэхүүний 58 хувь тус салбарт бүтээгдсэн байна. Уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа нь уг салбар дахь дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ тогтвортой өссөөр байгаа зэрэг хүчин зүйлсэс голлон хамаарч байна.

**Дэлхийн түүхий эдийн зах зээл дэх цийн өсөлт.** Түүхий эд олборлогч, экспортлогч хөгжиж буй орнуудын эдийн засгийн байдалд дэлхийн түүхий эдийн зах зээлийн төлөв байдал, өөрчлөлт хөдөлгөөн ихээхэн нөлөөтэй байдаг. Сүүлийн жилүүдэд түүхий эдийн зах зээл дэх үнийн өсөлт дэлхийн улс, орнуудын анхаарлыг ихээхэн татаж байгаа ба өнгөрөгч онд алт, зэсийн үнэ байнга өссөөр байсан нь манай улсын эдийн засгийн өсөлтөд ихээхэн дэмжлэг үзүүллээ.

**Алт.** Дэлхийн алтны жилийн олборлолтын дундаж хэмжээ 2400 тонн (буурч байгаа), харин нийт хэрэгцээ нь 3700 тонн байгаагаас нийлүүлэлтээсээ давсан эрэлтийн хэт өсөлтөөс үүдэлтэй үнийн өсөлт хадгалагдаар байна. Хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт хадгалагдах, газрын тосны өндөр үнэ хувээр байх нөхцөлд алтны дэлхийн зах зээлийн эрэлт өндөр хувээр байх хандлагатай байна. Энэтхэгийн уламжлалт ёс заншил, асар хурдацтай ёсч байгаа эдийн засгийн өсөлтийг дагасан алтны өндөр хэрэглээ болон Хятад, Дундад Азийн бусад орнуудын алтны эрэлт хэрэгцээний өсөлт нь суулийн жилүүдэд алтны эрэлт улам бүр нэмэгдэхэд голлон нөлөөлж байна. Дэлхийн алтны зөвлөлийн мэдээлснээр Энэтхэг улс дэлхийн үнэт эдлэл алтны хэрэглээний 20 хувийг эзэлдг байна. Зарим судлаачдын үзэж байгаагаар ойрын жилүүдэд нэг үнци алтны үнэ 1000-2500 ам. долларт хурч болзошгүй байна.

**Зэс.** Дэлхийн зэсийн хэрэглээ нь улс орон, бус нутгийн эдийн засгийн өсөлттэй шууд холбоотой өөрчлөгдеж иржээ. Өнгөрөгч онд зэсийн хэрэглээ 2005 оноос 17,2 сая тонн буюу 3,3 хувиар өссөн ба уг өсөлт Хятад, Энэтхэг, Европын орнууд, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнуудын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлтөөс ихээхэн хамаарсан гэж мэргэжилтнүүд дүгнэж байна. Зэсийг барилтын материал, цахилгаан бараа, цахим тоног төхөөрөмж, эрчим хүчний дамжуулалт, авто машины үйлдвэрлэлд өргөн хэрэглэдэг бөгөөд сүүлийн жилүүдэд Хятад, Япон, АНУ зэрэг орнууд дахь техник технологийн эрчимтэй хөгжил, автомашин, түүний эд анги, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, цахилгааны утас, агааржуулагч, цахилгаан бараа, компьютерийн үйлдвэрлэлийн өсөлт нь зэсийн хэрэглээг эрс нэмэгдүүлж үнийн өсөлтөд голлон нөлөөлж байна. 2007 оны таамаглалаар дэлхийн зэсийн хэрэглээний 44 хувийг Азийн орнууд, 17,3 хувийг өмнөд АНУ, 21,4 хувийг Европын орнууд, 17,3 хувийг бусад улс, орнууд бүрдүүлэх төлөвтэй байна.

**Хөдөө аж ахуйн салбар.** Өнгөрөгч онд байгаль цаг агаарын байдал тааламжтай байснаас малын хорогдол эрс буурч, ургац хураалт бүх төрөл дээр нэмэгдэн ХАА-н салбарын үйлдвэрлэл 9,7 хувиар өсөв. Өнөөдрийн байдлаар манай улсын ДНБ-ий 20 орчим хувийг ХАА-н салбар бүрдүүлж, нийт хүн амын 26,1 хувь нь ХАА эрхлэн амьдарч байна. Монгол улс 2006 онд 34,8 сая толгой мал тоолуулсан нь түүхэндээ хамгийн өндөр тоо болов. ХАА-н салбарын өсөлтөд хүн амын хүнсний хэрэглээнд нийлүүлж буй дотоодын ХАА-н бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлсэн, үндэсний үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах боломжийг бүрдүүлсэн, экспортын гол нэрийн зарим бүтээгдэхүүний билт хэмжээ эрс өссөн, болон банкны салбарын нийт олгосон зээлийн 8% нь уг салбарт зориулагдсан зэрэг үзүүлэлтүүд ихээхэн дэмжлэг үзүүлсэн байна.

**Боловсруулах аж үйлдвэрийн салбар.** Боловсруулах аж үйлдвэрийн салбар нь ДНБ-ний 6 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 18,6 хувийг үйлдвэрлэхийн зэрэгцээ манай орны хувьд ажлын байр бий болгогч томоохон салбарын нэг хэвээр байна. Боловсруулах салбарт төмөр, төмөр өдлэлийн үйлдвэрлэл 35-39%-иар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа ба хүнсний бүтээгдэхүүн, ундаа, нэхмэл өдлэл, ширэн өдлэл, гутал, цахилгаан хэрэгслэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах дэд салбаруудын үйлдвэрлэл өсөлт гарч бусад дэд салбаруудын үйлдвэрлэл буурчээ.

Хар төмрийн үнийн өсөлтийг дагаад уг салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь салбарын үйлдвэрлэл хөгжих гол нөхцөл болж байна. Монгол улс дэлхийд Хятад улсын дараа орох хоёр дахь томоохон түүхий ноолуур үйлдвэрлэгч улс бөгөөд түүхий ноолуурын 30 орчим хувийг дотооддоо боловсруулдаг. Түүнчлэн сүүлийн жилүүдэд хулдаасан хэвлэл, нэг удаагийн аяга тавга, молибдений исэл, хөөсөнцөр хавтан, зам талбайн хавтан зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэн импортыг орлуулах чиглэлийг ихээхэн дэмжиж байгаа нь боловсруулах салбарын хувьд гарсан дэвшил юм.

Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний экспортын нөхцөл ихээхэн тааламжтай болж байгаа ба өнгөрөгч онд уг салбарын нийт борлуулалтын 34,5% нь олон улсын зах зээлд хийгдсэн байна. Мөн 2006 онд банкны системээс олгосон нийт зээлийн 9 хувь буюу 167 тэрбум төгрөгийн зээл уг салбарт олгогдсон нь өмнөх онтой харьцуулахад 10,1 хувиар өсчээ.

**Барилгын салбар.** Нийгмийн хөгжлийг дагаад барилгын салбар тэргүүлэх ач холбогдолтой салбаруудын нэгэнд зүй ёсоор тооцогдож байна. Өнгөрөгч онд хийгдсэн нийт барилга угсралт, их засварын ажлын 84,4 хувийг дотоодын, 15,6 хувийг гадаадын барилгын байгууллагууд гүйцэтгэсэн бөгөөд уг салбарт нийт 858,2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, банкны системийн олгосон нийт зээлийн 7 хувь буюу 136 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна. Улс орны хөгжлийг дэмжих, айл өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилго бүхий төсөл хөтөлбөрүүдийн гол цөм нь айл өрхийг орон сууцжуулах, хотжуулах асуудал болж байгаатай холбоотойгоор ойрын жилүүдэд барилгын салбарын өсөлт нэмэгдэх хандлагатай байна.

**Тээвэр, холбоо.** Өнгөрөгч онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэж өнгөрүүлсэн, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэн, үүрэн телефоны оператор болон хэрэглэгчдийн тоо өссөн зэрэгтэй холбоотойгоор тээвэр холбооны салбар 14%-иар өссөн байна. 2006 онд уг салбарт олгогдсон зээлийн хэмжээ 73 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 20,7 хувиар нэмэгджээ. 2006 онд бүх төрийн ачаа тээвэрлэлт 1,3 хувь, зорчигч тээвэрлэлт 1,4 хувиар өссөн бол шуудан холбооны салбарын орлогын өсөлтөнд суурин телефоны цэгийн өсөлт, утасгүй телефоны тоо, үүрэн телефоны хэрэглэгчдийн тоо, кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо өссөн зэрэг нь голлон нөлөөлжээ.

2007 онд төмөр замд техникийн шинэчлэлийг үргэлжлүүлж, тээх нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг өсгөх, улс, хот хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийг олон улсын стандартад нийцүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэл баримталж байна. Мөн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлтийг үргэлжлүүлж, Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөх олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, олон улсын нисэх онгоцны буудал барих техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны үнэлгээ хийх зэрэг ач холбогдол бүхий олон ажил төлөвлөгдөх байгаа нь тээврийн салбарын ирээдүйн өсөлтийг харуулж байна.

**Худалдаа, цийлчилгээний салбар.** Худалдааны салбарын нийт борлуулалт 2006 онд 823,1 тэрбум төгрөг болж өнгөрсөн оноос 18,1 хувиар өссөн ба үүнд импортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд болон автобензины импорт 39,8 хувь, дизель түлшний импорт 28,6 хувь, онгоцны түлшний импорт 2,8 дахин өссөн нь голлон нөлөөлжээ. Худалдааны салбарын нийт борлуулалтын 55,2 хувийг бөөний худалдаа, 44,8 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна. 2006 онд банкны системийн олгосон нийт зээлийн 37 хувь буюу 721 тэрбум төгрөгийн зээл тус салбарт олгогдсон нь өмнөх онтой харьцуулахад 23,05 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын төсвийн гүйцэтгэл	2000	2001	2002	2003	2004	2005	2006
<b>Нийт орлого, тусламжийн дүн</b>	<b>351.1</b>	<b>439.3</b>	<b>477</b>	<b>553.9</b>	<b>713.1</b>	<b>837.9</b>	<b>1 353.2</b>
Ургал орлого	346.2	430	469.8	545.2	706.3	832.6	1 346.8
Хөрөнгийн орлого	0.1	0.2	0.5	0.0	0.8	1	1.7
Тусламж	4.8	9.2	6.8	8.7	6.1	4.3	4.7
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>429.7</b>	<b>489.7</b>	<b>548.6</b>	<b>615.8</b>	<b>752.5</b>	<b>764.6</b>	<b>1 228.7</b>
Ургал зардал	314.1	366.7	413.5	434.8	538.7	600.3	978.5
Хөрөнгийн зардал	52.6	59.1	68.1	90.5	104.9	89.8	177.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	63	63.9	67.1	90.5	108.4	74.5	72.7


Өнгөрөгч онд улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2006 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1353,2 тэрбум төгрөг, нийт зардал 1228,7 тэрбум төгрөг болж нийт тэнцэл 124,5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Нэгдсэн төсвийн орлогын 83,2 хувийг татварын орлого, 16,3 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн дунтэй байгаа ба өмнөх онтой харьцуулахад татварын орлогын төсвийн орлогод эзлэх хувийн жин 0,6 пунктээр өсч, татварын бус орлогын хувийн жин 0,5 пунктээр тус тус буурсан байна. Нэгдсэн төсвийн зарлагын 20,9 хувийг нийгмийн даатгал, халамжийн, 15,7 хувийг боловсролын, 8,1 хувийг эрүүл мэндийн, 16,6 хувийг нийтийн үйлчилгээний, 26,8 хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарт тус тус зарцуулсан нь зарлагын бүтцэд өндөр хувийг эзэлж байна.

Улсын төсвийн орлого 2005 онд ДНБ-ий 37 орчим хувьтай тэнцэж байсан бол 2006 онд 42.7 хувь болж өссөн нь засгийн газраас өрх гэрт олгох шилжүүлэг болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэнээр эдийн засаг дахь нийт эрэлт нэмэгдэж, үйлдвэрлэлийг өсгөх боломжийг бүрдүүлсэнээс ихээхэн хамаарсан гэж мэргэжилтнүүд дүгнэж байна.

## МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ, БАНК САНХҮҮГИЙН СИСТЕМ

### Инфляци




2006 оны эцсийн байдлаар хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляци суурь он буюу 2000 оны 12-р сараас 47,9%, өмнөх оноос 6%-иар өссөн байна. Инфляцид эм тариа эмнэлгийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээний үнэ нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.


Банкны системийн үндсэн үзүүлэлтүүд	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Банкуудын тоо	12	16	16	17	17	17	16
Банкны салбар, тооцооны төв, кассын тоо	457	538	595	635	684	732	832
1салбарт ноогдох хувийн тоо	5 268	4 540	4 160	3 943	3 703	3 501	3 132
1 хүнд ноогдох хадгаламжийн хэмжээ	38	55	88	145	204	270	374
Нийт хөрөнгө ДНБ-ний харьцаа	23,1%	29,4%	39,7%	60,6%	59,5%	70,0%	73,0%
Нийт зээл ДНБ-ний харьцаа	6,6%	12,1%	18,7%	32,5%	33,5%	36,8%	38,5%
Нийт өөрийн хөрөнгө ДНБ-ний харьцаа	3,1%	4,2%	5,0%	8,1%	9,3%	9,1%	9,3%
Чанаргүй зээлийн хувь	21,9%	6,7%	5,1%	4,8%	6,4%	5,6%	4,9%
Өөрийн хөрөнгийн хурэлцээ	27,0%	24,6%	20,0%	20,4%	20,0%	18,2%	18.1%
Нийт хөрөнгөнд төрийн оролцоо	56,6%	48,0%	22,1%	7,3%	6,0%	4,9%	-
Нийт хөрөнгөнд гадаадын хөрөнгө							
оруулалтын оролцоо	-	-	21,9%	33,9%	29,4%	29,0%	49,0%
Банк бус санхүүгийн байгууллага	7	28	66	88	114	150	163

### ХҮҮГИЙН ТҮВШИН

Төгрөгийн хүц



Гадаад валютын хүц




2006 оны туршид банкуудын зарласан хадгаламжийн хүү тогтвортой, зээлийн хүү харьцангуй хэлбэлзэлтэй боловч буурах хандлагатай байв. 2005 оны эцэст төгрөгийн зээл, хадгаламжийн зарласан хүүгийн зөрүү 9,1% байсан бол 2006 оны эцэст 5,1% болж 4 пунктээр буурсан байна. Харин гадаад валютын хувьд уг зөрүү тогтвортой 4% хэвээр байв.

## ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2006 онд 1,9 триллион төгрөгийн зээл олгогдож, 1,6 триллион төгрөгийн зээл төлөгдөн оны эцэст 1,2 триллион төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан ба зээл олголт өмнөх оноос 39%-иар нэмэгджээ. Зээлийн зориулалтыг эдийн засгийн сектороор авч үзвэл бүтцэд нь өмнөх оноос отцом өөрчлөлт ороогүй бөгөөд худалдааны салбарт хамгийн их зээл олгогджээ.

### Олгосон зээл /зориулалтгаар/




ОНГӨРӨГЧ ОНД НИЙТ ЗЭЭЛИЙН БАГЦАД ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЭЗЛЭХ ХУВЬ 1 ПУНКТЭЭР БУУРЧ 5% БОЛСОН НЬ ЗЭЭЛИЙН ЧАНАРТ БАГА Ч БОЛОВ АХИД ГАРЧ БАЙГААГ ХАРУУЛЛАА.


## ХАРИЛЦАГЧДААС ХАДГАЛАМЖ, ХАРИЛЦАХ ТАТАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мөнгөний нийлүүлэлтэнд бараг мөнгө буюу иргэд байгууллагын төгрөг, гадаад валютын хадгаламж, гадаад валютын харилцахын эзлэх хувь өмнөх оноос 2 пунктээр нэмэгдэж 78% буюу 1,2 триллион төгрөгт хүрсэн байна.

### Бараг мөнгөний нийт мөнгөн нийтийн эзлэх хувь



### Харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



2006 оны эцэст харилцагчдаас нийт 350 тэрбум төгрөгийн харилцах, 971 тэрбум төгрөгийн хадгаламжийг банкуудад төвлөрүүлээд байгаа бөгөөд нийт харилцахын 57% -ийг хувийн секторын, 16%-ийг улсын байгууллагын, 14%-ийг иргэдийн харилцах, нийт хадгаламжийн 94%-ийг иргэдийн хадгаламж эзэлж байна. Хадгаламж 276,8 тэрбум төгрөгөөр өссөн нь урьд өмнө гарч байгаагүй өндөр өсөлт ба үүнд эдийн засгийн ерөнхий өсөлт голлон нөлөөлжээ.

# Бид Дэлхийн Хөгжилтэй Хамт



# Хэтийн Зорилго, Эрхэм Зорилго, Зорилт

## ■ Хэтийн зорилго

Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.

## ■ Эрхэм зорилго

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.

## ■ Зорилт

- Голомт банк нь үнэ цэнэтэй, нээлттэй хувьцаат компани болох
- Нийт актив, өөрийн хөрөнгө, ашгийн хэмжээгээр банкны системд тэргүүлэгч болох
- Улаанбаатар хотын салбаруудыг зорилтоор төрөлжүүлэн тэргүүлэх чиглэлтэй болгох, орон нутгийн салбаруудыг бус нутгийн тэргүүлэгч байранд хүргэх
- Иргэд болон жижиг бизнесийн байгууллагад санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлж салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх
- Банкны салбарт тэргүүлэх технологийн өөрчлөлт хийх замаар харилцагчдадаа хүргэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх

# Бүтэц, Зохион Байгуулалтын Схем



# Үдирдлагын Баг



**Н. Нацагдорж**  
Дэд Ерөнхийлөгч,  
Үйлчилгээ, Харилцагчийн  
Газрын Захирал

**Л. Оюун-Эрдэнэ**  
Дэд Ерөнхийлөгч,  
Зээлийн Газрын  
Захирал

**Д. Сугар**  
Төлбөр Тооцооны  
Хэлтсийн Захирал

**М. Чимэгмөнх**  
Дэд Ерөнхийлөгч,  
Санхүүгийн Мэдээлэл  
Хяналтын Газрын  
Захирал

**Н. Чингүн**  
Эрдлийн Үдирдлагын  
Хэлтсийн Захирал

**Н. Цэрэндаваа**  
Мэдээлэл Технологийн  
Хэлтсийн Захирал



Г. Ганболд  
Дэд Ерөнхийлөгч,  
Ерөнхий Зохицуулалтын  
Газрын Захирал

С. Энхтувшин  
Картын Төвийн  
Захирал

Г. Ганхуяг  
Дэд Ерөнхийлөгч,  
Ноёцийн Газрын  
Захирал

Ж. Ганбат  
Дотоод Хяналтын  
Хэлтсийн Захирал

Б. Батнягт  
Маркетингийн  
Хэлтсийн Захирал

# Өнгөрөгч онд ГОЛОМТ БАНК

## БИЗНЕСИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА

### ХУНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

Голомт банк 2006 оны эцсийн байдлаар нийт 548 ажилтантай байгаагийн 200 гаруй нь тайлант хугацаанд шинээр ажилд орсон байна. Шинээр ажилд орогсдын тоо өмнөх онтой харьцуулахад 1,3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд нийт шинэ ажилтнуудын 70% нь салбар, тооцооны төвүүдэд, 30% банкны төв оффист томилогдон ажиллаж байна. Ажилтнуудын дундаж нас 29, дундаж ажилласан хугацаа 3 жил байгаа ба нийт ажилтнуудын 90% нь дээд боловсролтой, түүний 70 % нь Банк санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага чиглэлийн, 30% нь бусад мэргэжлийн хүмүүс байна.

Байгууллагын гол баялаг нь хүн байdag бөгөөд тэднийг хөгжүүлэхэд чиглэгдсэн төрөл бүрийн шинэлэг үйл ажиллагаануудыг зохион байгуулсаар ирсэн уламжлалаа бид өнгөрөгч онд хадгалж, хөгжүүлэв. 2006 онд Голомт банкны хамт олны нэг гишүүн болж, шинээр ажилд орсон ажилтнууддаа зориулж “Шинэ ажилтан хүлээн авах ёслол”-ын үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэний дээр ажилтан бүрийг санаачлагатай, бүтээлч ажиллуулахын төлөө “Кайzen саналын систем”-ийг амжилттай хэрэгжүүлж байна. Жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн сургалтын жилийн нээлтийн хүрээнд “Төгс баг” удирдах ажилтны сургалт, семинарыг зохион байгуулж, хүний нөөц болон сургалтыг сайжруулах чиглэлээр хэд хэдэн төслүүдийг хэрэгжүүлж байна.

2006 онд нийт 100 орчим сургалтанд давхардсан тоогоор 720 ажилтан хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн бөгөөд банк эдгээр сургалтуудад 100 сая төгрөгийн зардал гаргасан байна. Мөн СЭЗДС, Солонгосын Хандоны Глобал Их Сургуулийн хамтарсан магистрын хөтөлбөрт Голомт банкны ажилтнууд үргэлжлэн хамрагдсаар байгаа бөгөөд тайлант онд 2 ажилтан тус хөтөлбөрийг амжилттай төгслөө.

Голомт банкны хамт олон ямагт үлгэр жишээ, манлайлагч байдгийг бататган 2 ажилтан банкны салбарын тэргүүний ажилтан болсон амжилтаар бид 2006 оныг үдлээ.



*Манайд зөвхөн шилдгүүд ажилладаг*

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЙЛАН


### 1. Бэлэн мөнгөний автомат машиныг үйлчилгээнд нэвтрүүлэв.

Карт хэрэглэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр тэдэнд хөнгөн шуурхай үйлчлэх боломжийг нэмэгдүүлэх, карт мөнгөжүүлэх цэгүүдийн тоог олон болгох шаардлага зүй ёсоор тавигдсаар ирсэн билээ. Өнгөрөгч онд бид энэхүү шаардлагыг амжилттай биелүүлж Малайзын Sungard System Access Malaysia компанийтай хамтран Германы Wincor Nixdorf компаний ATM машинуудыг үйлчилгээнд нэвтрүүллээ. Эдгээр ATM-үүд нь мастеркарт карт болон виза картаар үйлчилдэгээрээ бусад ATM-үүдээс онцлог бөгөөд бид Мастеркарт Интернэйшил байгууллагын Cirrus, Виза Интернэйшил байгууллагын Plus сертификатуудыг авч монголд анх удаа энэхүү боломжийг нээллээ. Одоогоор уг ATM машинууд нь бэлэн мөнгө авах, үлдэгдэл харах, хуулга харах, картын шилжүүлэг, пин код солих зэрэг үйлчилгээг үзүүлж байна.

### 2. Мэдээллийн технологийн аудит хийлгэв.

Банкны үйл ажиллагааны цар хүрээ өдөр ирэх бүр өргөжин тэлж мэдээллийн технологид сууриссан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо, хамрах хүрээ нь нэмэгдсээр байна. Өнгөрөгч онд бид банкныхаа мэдээллийн технологийн аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэх, цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөмж авах зорилгоор Францын Thales группийн Thales E-Security компаниар компьютерын системийн аудит хийлгэлээ. Энэ ажлын хүрээнд компьютерын систем, сүлжээ, програм хангамжийн ажиллагааны зарчим, найдвартай, аюулгүй байдал, нууцлалын аудит хийлгэж, өдөр ирэх бүр өсөн нэмэгдсээр байгаа мэдээллийн технологийн хэрэгцээ, шаардлагад хэрхэн нийцэж ажиллах талаар зөвлөмж авсан нь бидний ажилд ихээхэн дэмжлэг үзүүлж байна.

### Голомт Банкны ATM-ын байршилүүд



## **НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ**

Голомт банк нийгэмд чиглэсэн ўйл ажиллагааны оролцоогоо жил бүр нэмэгдүүлсээр ирсэн бөгөөд өнгөрөгч 2006 онд нийгэм, олон нийтэд чиглэсэн хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулж, нэлээд олон тооны арга хэмжээнд оролцлоо. Тухайлбал, нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 367 жилийн ойн баярыг угтаж 2006 оны 10 дугаар сарын 26-ны өдөр “Автобус 1”, “Автобус 2” компанийн нийтийн тээврийн том автобуснууд зорчигчдод үнэ төлбөргүй үйлчлэх ажлыг Голомт банк санаачлан зохион байгуулсан бөгөөд энэ ўйл ажиллагаанд ойролцоогоор 12 000 гаруй иргэн хамрагдсан байна.

Хүүхдийн сурч амьдрах орчин нөхцлийг сайжруулах, хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдэд туслах сайхан сэтгэлийн аянаа бид өнгөрөгч онд ч үргэлжлүүллээ. Энэ аяны хүрээнд бид эх үрсийн баярыг тохиолдуулан “Дэлхийн Зөн” ОУ-ын байгууллагын “Хүнд нөхцөл дэх хүүхэд” төсөлд хамрагдаж буй хүүхдүүдийг 5-р сарын 31-ний өдөр банкныхаа ўйл ажиллагаатай танилцуулан, хамтдаа үдийн зоог барьж, хүүхдийн баярын бэлэг гардуулсаны дээр “Ирээдүйн түлхүүр сан”, Иточу корпорацитай хамтран Сонгинохайрхан дүүргийн Хүүхдийн хөгжлийн төвийн дэргэдэх “Ачлал” сургуулийн хичээлийн байрны барилгад 5 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлэв. Мен хүнд нөхцөлд амьдарч буй хэд хэдэн хүүхдэд хадгаламжийн дэвтэр нээж, хоёр хүүхдийн нэр дээр хандивын данс ажиллуулж байна.

Олон нийтэд чиглэсэн уламжлалт арга хэмжээнүүдийн нэг нь 2003 оноос хэрэгжүүлж эхэлсэн сургалтын тэтгэлэг олгох хөтөлбөр юм. 2006 онд уг хөтөлбөрт 58 их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа 100 оюутан хамрагдаж нийт 36 сая төгрөгийн тэтгэлэг хүлээн авсан байна. Өнгөрөгч онд бид жил бүр уламжлал болгон зохиодог оюутны эрдэм шинжилгээний бага хурлаа амжилттай зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд 16 их дээд сургуулийн 107 оролцогчдын 68 илтгэл оролцов.

Дээрх уламжлалт арга хэмжээнүүдээс гадна бид Монгол улсынхаа спортын хөгжилд хувь нэмрээ оруулах, олон улсын уралдаан тэмцээнд оролцох баг тамирчдаа тусалж дэмжих болон агаарын бохирдолтой тэмцэх ўйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлэх чиглэлээр нэлээд идэвхитэй ажиллалаа.

## **БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **САЛБАР, ТООЦООНЫ ТӨВҮҮД**

Өнгөрөгч онд салбар нэгжүүдийн хүрээнд хэд хэдэн томоохон өөрчлөлтүүд хийгдлээ. Голомт банкны борлуулалтын гол цөм болсон дараах томоохон тооцооны төвүүд салбарын статустай болж үйл ажиллагааны цар хүрээ өргөжив.

- Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд 1 , 5 дугаар салбарууд
- Баянзүрх дүүргийн 7 дугаар хороонд 2 дугаар салбар
- Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд 6 дугаар салбар
- Сонгино Хайрхан дүүргийн 12 дугаар хороонд 7 дугаар салбар
- Баян гол дүүргийн 14 дүгээр хороонд 8 дугаар салбар

Мөн 2006 онд бид харилцагчдын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан Улаанбаатар хотод 3 салбар, хөдөө орон нутагт 2 тооцооны төвийг шинээр нээж борлуулалтын сүлжээгээ өргөтгөв. Мөн салбар, тооцооны төвүүдээс гадна харилцагчдын хүсэлтээр бэлэн мөнгө ихээр төвлөрдөг томоохон цэгүүддэд хэд хэдэн кассыг нээн ажиллуулсан нь харилцагчдын талархлыг ихээхэн хүлээж байна.

- 12 дугаар салбарыг Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороонд
- 16 дугаар салбарыг Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороонд
- 17-р салбарыг Сонгино Хайрхан дүүргийн 14 дугаар хороонд
- 1 салбарын харьяа 11 дүгээр кассыг 3 дугаар хорооллын Мобикомын байранд,
- Дархан-уул аймгийн салбарын харьяа 15 дугаар кассыг Сэлэнгэ аймгийн Дулаанхаан хороонд
- Орхон аймаг дахь салбарын харьяа 16 дугаар кассыг Мобикомын байранд
- Мөн уг суманд 12, 14 дүгээр кассууд нээгдэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөө орон нутгийн ард түмэнд орчин үеийн банкны үйлчилгээг хүргэх зорилгоор Голомт банкны 13, 18 дугаар тооцооны төвүүдийг Дорноговь аймгийн Замын-Үүд сум, Хөвсгөл аймгийн Мөрөн хотуудад нээллээ.



## Шилдэг үйлчилгээ тохилог орчин




Салбар, нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх замаар харилцагчдад банкны үйлчилгээг ойртуулахын зэрэгцээ тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр бид өнгөрөгч онд нэлээд ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгын хүрээнд Картын төв, Хувийн Банкны Албаны үйлчилгээний орчинг бүхэлд нь өөрчилж, эдгээр нэгжүүд орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинэ байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хотын төвд байрладаг 5 дугаар салбарыг теллерийн системд бүрэн шилжүүлж харилцагчид нэг цэгээс түргэн шуурхай үйлчилэх боломжийг бүрдүүллээ. Бүх салбар, нэгжүүдэд харилцагчийн санал гомдлыг хүлээн авах хайрцаг ажиллуулсан, харилцагчдын санал гомдлыг тухай бүр шийдвэрлэх, хариу өгөх үйл ажиллагааг идэвхижүүлсэн нь мэдэгдэхүйц үр дүнгээ өгч байна.

## ЦАХИМ БАНК

2006 онд Голомт банк цахим үйлчилгээг харилцагчдад улам ойртуулах, цар хүрээг өсгөх чиглэлд анхаарч ажиллалаа. Өнгөрөгч онд шинээр байгуулагдсан бүх нэгжүүд болон зарим нэг оффлайн горимоор ажиллаж байсан нэгжүүдийг онлайн горимд шилжүүлсэнээр системийн хэмжээгээр Хөвсгөл, Дорнод аймгууд дахь 2 салбараас бусад бүх нэгжүүд онлайн горимоор ажиллаж харилцагчид хүссэн цэгээсээ үйлчлүүлэх боломж нээлттэй болов.

2006 оны 9-р сараас эхлэн Гаалийн Ерөнхий Газартай хамтран гаалийн бурдуулэлтийн төлбөрийг интернетээр хийх үйлчилгээг нэвтрүүлсэн нь харилцагчдад түргэн шуурхай үйлчлэхийн зэрэгцээ гадаад худалдааны таатай орчинг бурдуулэх бодитой алхам болов.

### Интернет банкны үзүүлэлтүүд



Харилцагчид интернэт банкаар үйлчлүүлэхийн давуу талуудыг улам бүр ойлгож, интернет банкаар үйлчлүүлэгчдийн тоо өссөөр байгааг тоон үзүүлэлтүүд харуулж байна. Интернэт банкаар үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оноос 46,4%-иар, хийгдсэн гүйлгээний мөнгөн дун 143%-иар тус тус өсчээ.


Өнгөрөгч онд электрон банкны үйлчилгээнд нууцлалын түвшинг нэлээд сайжруулсан бөгөөд электрон банкаар үйлчлүүлэгчдийн тоо 2,6%-иар өссөн байна.

### ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2006 онд Голомт банкны харилцах, хадгаламжийн нийт дүн өмнөх оноос 22%-иар өсөж 283.7 тэрбум төгрөгт хүрсэн нь банк санхүүгийн системийн нийт харилцах, хадгаламжийн 19%-ийг эзэлж байгаа бөгөөд харилцах, хадгаламжинд төлсөн хүүгийн зардал 17.4 тэрбум төгрөгт болж өмнөх оныхоос 39 %-иар өссөн байна.

Бид харилцагчиддаа хадгаламжийн уян хатан сонголтыг олгох үүднээс энгийн хадгаламжийг 1-12 сарын аль ч хугацаатайгаар байршуулах боломжийг бий болголоо.

Мөн хадгаламжийн хүүг хугацаанаас өмнө урьдчилан олгох урьдчилсан хүүт хадгаламж, тогтмол хугацаанд хадгаламж хийсээр хуримтлал үүсгэх сонирхолтой харилцагчдад зориулан хуримтлалын хадгаламж, харьцаангуй өндөр хүйтэй энгийн хадгаламжийн сертификат зэрэг бүтээгдэхүүнийг харилцагчдад шинээр санал болголоо.



## ТӨЛБӨРИЙН КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ


Голомт банк нь Дэлхий нийтийн брэнд болсон MasterCard карт, VISA картуудыг Монгол улсад анх нэвтрүүлсэн билээ. Салбartaа анхдагч байж шинэ дэвшилтээ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, картын хэрэглээ бэлэн бус төлбөр тооцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Голомт банк VISA Platinum, Монголын Оюутны Холбоотой хамтран “Монголын оюутны хөнгөлөлтийн VISA Electron, Maestro карт”, БНХАУ-ын Тариалангийн банк China UnionPay банкуудтай хамтын ажиллагааны хүрээнд “Алтан туруу” юаны карт зэрэг төслүүдийг амжилттай нэвтрүүлж байсан бөгөөд өнөөдрийн байдлаар эдгээр бүтээгдэхүүний хэрэглээ зах зээлд төлөвшиж картын зах зээл дэх банкны байр суурийг улам бүр бэхжүүлсээр байна. Түүнчлэн бид Зоос, Капитрон, Хас банкуудтай тогтоосон хамтын ажиллагааны хүрээнд картын зах зээлийн цар хүрээг улам бүр тэлсээр байна.

Өнгөрөгч онд MIAT ХК-тай хамтран MIAT Mileage КоBrэнд карт, Эйрнэтворк ХХК-тай хамтран Airnetwork Mileage Алтан карт, Хөлбөмбөгийн ДАШТ-нд зориулан уг тэмцээний ерөнхий ивээн тэтгэгч Mastekart Ворлдвайд байгууллагатай хамтран гаргасан карт зэрэг картын шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргаж бэлэн мөнгөний автомат машиныг үйлчилгээнд амжилттай нэвтрүүллээ. Мөн нийгмийн сайн сайхны төлөөх үйл ажиллагааны хүрээнд Итали улсын Турин хотноо болсон Өвлийн олимпод Монгол улсаас оролцсон баг тамирчдаа дэмжин Torino-2006 Виза картыг зах зээлд гаргав.

Мөн картын хэрэглэгчдийг интернетээр төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэнээр интернет худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын чиглэлэйн 30 гаруй байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг онлайнаар худалдан авах боломжтой болоод байна. Ингэснээр харилцагчид www.ntc.mn, www.on-air.mn, www.cip.mn гэх мет олон сайтаар аялан Мобикартын нэгжийн карт, онлайн кино, клип үзэх, оффисын бараа бүтээгдэхүүн худалдан авах зэрэг үйлчилгээг авч байна. Мөн Голомт банкны www.egolomt.mn сайтад нэвтрэн төлбөрийн картын үлдэгдэл, хуулгаа үзэх, орон сууц, байр цахилгааны төлбөрөө төлөх боломжтой боллоо.

2006 оны эцсийн байдлаар нийт карт эзэмшигчдийн тоо 208 900-д хүрсэн бөгөөд тайлант хугацаанд бид 66 200 карт шинээр борлуулжээ. Нийт картаар хийгдсэн гүйлгээний хэмжээ өмнөх оны мөн үеэс 60%-аар өсч 68,0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд төлбөрийн картаар цалингаа тавьдаг байгууллагуудын тоо өмнөх оныхоос 49%-аар өсч 368-д хүрсэн зэрэг нь карт эзэмшигчдийн картын талаарх мэдээлэл, хэрэглээ өргөжиж байгаагийн илрэл юм.

*Картаар цүлчлэгч байгууллага*



Харилцагчдад үзүүлэх картын үйлчилгээг илүү түргэн шуурхай, соёлч боловсон болгох, нэг цэгээс бүх бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх, борлуулах зорилгоор картын төрөл бурийн бүтээгдэхүүн үйлчилгээг банкны бүхий л салбар тооцооны төвүүдээр тараан байршуулж, картын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлээ. Бид цалингаа төлбөрийн картаар авдаг харилцагчдаа хөхүүлэн дэмжих, картын хэрэглээг идэвхжүүлэх зорилгоор бага хүйтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлээ үргэлжлүүлэн олгосоор байгаа бөгөөд зээл олголт өмнөх оноос 70%-оөр өсч 2,6 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2006 оны эцсийн байдлаар нийт карт эзэмшигчдийн 10 гаруй хувь нь олон улсын карт эзэмшигчид байгаа бөгөөд олон улсад хэрэглэгдэх зээлийн картын тоо 30%-аар, зарцуулалт хэрэглээ нь 56%-аар тус тус өсч 756,0 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн 2006 оны эцсээр картын харилцах дансны үлдэгдэл 7,8 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Сүүлийн жилүүдэд бид харилцагчдын төлбөр тооцоог илүү түргэн шуурхай, найдвартай гүйцэтгэх, автоматжуулах тал дээр голлон анхаарч байгаа ба Голомт банкны карт эзэмшигчид Голомт банк болон мөнгөжүүлэгч банкуудын 102 салбар тооцооны төвүүд, 427 картаар үйлчлэгч худалдаа үйлчилгээний байгууллагууд, 27 вэб сайт, 10 ATM-ээр үйлчлүүлэх боломжтой болоод байна.

### **ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

2006 онд Голомт банк 298.7 тэрбум төгрөгийн зээл олгож, 250.1 тэрбум төгрөгийн зээл төлүүлэн, 21.8 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн орлого олж оны эцсийн байдлаар 186 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байв. Өмнөх онтой харьцуулахад зээл олголт 53.1 %-иар, зээлийн хүүгийн орлого 28.2%-иар, зээлийн өрийн үлдэгдэл 34,5%-иар өсч, банкны системийн хэмжээний зээлийн өрийн үлдэгдлийн 15,2 %-ийг Голомт банк бурдуулж байв.

Өнгөрөгч онд Голомт банк нь өрийн эх үүсвэрээс 27 гаруй нэр төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг идэвхтэй олгосны дээр манай улсад хэрэгжиж буй бүх төрлийн төслийн зээлийг олгох үйл ажиллагаанд идэвхитэй оролцож зах зээлд хямд үнэтэй зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх чиглэлд анхаарч ажиллалаа. Тухайлбал, АХБ-ны “Ажлын байр нэмэгдүүлэх”, “Орон сууцны санхүүжилтийн”, ХЭДС-ийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслүүдэд дамжуулан зээлдүүлэгчээр үргэлжлүүлэн оролцов. Мөн МУ-ын засгийн газар Японы хөрөнгө оруулалтын банкны хамтран хэрэгжүүлж буй “Байгаль орчинд хор хөнөөлгүй, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих” төслийн дамжуулан зээлдүүлэгчээр шалгарч бага хүйтэй, урт хугацааны зээлийг зах зээлд борлуулах боломжтой болоод байна.


2006 онд Засгийн газрын зүгээс Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, иргэдийг орон сууцжуулах зэрэгт түлхүү анхаарал хандуулсантай холбоотойгоор манай банкны зүгээс ч мөн энэ тал дээр түлхүү анхаарч нийт багцад эзлэх бизнесийн жижиг зээл, хөрөнгө оруулалтын зээл, орон сууцны зээлүүдийн хувийг өмнөх оны мөн үеийнхээс өсгөж ажиллалаа.

Бүтээгдэхүүний төрөл	Багцад эзлэх хувь
ААН-ийн эргэлтийн зээл	78.06%
Бизнесийн жижиг зээл	9.14%
Банк, санхүүгийн байгууллагуудад олгосон зээл	0.32%
Орон сууцны зээл	4.19%
Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн зээл	0.43%
Хөрөнгө оруулалтын зээл	3.82%
Бусад	4.03%
<b>Дүн</b>	<b>100%</b>




Бид нэг гэр бүл

**Зээлийн зориулалтын ангилал**



**Зээлийн жилийн жигнэсэн дундаж хүч  
/2006.01-2006.12/**




Мөн өнгөрөгч онд зээлийн хүүг бууруулах, 1 зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг нэмэгдүүлэх зорилго тавин ажилласан ба үүний үр дүнд зээлдэгчийн тоо өсч, хүүгийн дундаж түвшин буурсан байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрчимжиж, жижиг зээлийн эрэлт өсч байгаатай холбогдуулан салбараар зээл олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлийг барьсан дүнд оны эцэст салбараар олгосон зээлийн хэмжээ 80.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант онд зээлийн үйл ажиллагаанд дараах гол өөрчлөлтүүд хийгдлээ. Үүнд:

- 1356 гаруй ажлын байр бий болгон, 352 гаруй өрхөд орон байрны нөхцлөө сайжруулахад нь санхүүгийн дэмжлэг үзүүллээ.
- Бизнесийн жижиг зээлийн хүүг алхамтайгаар бууруулах хэлбэрийг бий болгож хүүгийн дээд, доод түвшинг 1,9%-2,5% болгон бууруулав.
- Бизнесийн жижиг зээлийн хэмжээг нэмэгдүүлж нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 100 сая төгрөг болгов.
- Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээлийн хүү 1.8% болж 1 пунктээр буурав.
- Тогтмол орлоготой иргэдийн хувийн хэрэгцээнд зориулсан шуурхай зээлийн хэмжээ 5.0 сая төгрөг болж нэмэгдэн хүүгийн хэмжээ 3.0% болж буурсан.
- Импортоор бараа оруулж ирдэг бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор импортын зээлийн дээд хэмжээг 500.0 сая төгрөг болгон нэмэгдүүлэв.
- Төрөөс өндөр настануудын хангамжийг дээшлүүлэх зорилгоор тэтгэвэрийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан тэтгэвэрийн зээлийн дээд хэмжээг 400.0 төгрөг болгон тэтгэврийн дээд хэмжээтэй дүйцүүлэв.
- Салбараар олгох зээлийн төрлийг нэмэгдүүлж, зээл олголтыг эрчимжүүлэв.
- Картын цалингийн зээлийн олголтыг нэмэгдүүлэх, уг зээлийг идэвхижүүлэх зорилгоор салбар нэгжүүдээр олгож эхэлсэн.
- Салбар нэгжүүдээр олгож байгаа бизнесийн жижиг зээлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бүтээгдэхүүний төрөл, зээлийн багцыг нэмэгдүүлэх, найдвартай сайн харилцагчдыг татах зорилгоор ам.долларын болон юаны бизнесийн жижиг зээлийг олгож эхэллээ.
- Худалдаа эрхэлдэг зээлдэгчдэд зориулан Худалдааг дэмжих зээлийг гаргав. Ингэснээр зээлдэгчдийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, түр зуурын санхүүгийн дутагдлыг санхүүжүүлэх боломжийг бүрдүүллээ.
- Зээлийн төвийг Улаанбаатар хотын төв гудамж Энхтайваны өргөн чөлөөнд нээсэн нь байршилын хувьд маш зөв шийдэл болж уг төв нээгдсэнээсээ хойш 8 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.

## **ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Харилцагчид, түншүүдийнхээ өсөн нэмэгдсээр байгаа санхүүгийн хэрэгцээг хангах зорилгын хүрээнд Голомт банк 2006 онд АНУ-ын American Express Bank, БНХАУ-ын Industrial and Commercial Bank, Япон улсын Sumitomo Mitsui Banking Corporation, Mizuho Corporate Bank, Казакстан улсын Kazkommertsbank зэрэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудтай корреспондент харилцаа тогтоолоо. Мөн гадаад гүйвуулгын хүү шимтгэлийг бууруулах, хөрөнгийг оновчтой байршуулах, гадаад зах зээл дэх үр ашигтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор өмнө тогтоосон харилцаагаа өргөжүүлэх, бэхжүүлэх чиглэлд нэлээд анхаарч ажиллалаа. Үүний үр дунд Commerz Bank, Frankfurt, New York; Export-Import Bank of the Republic of China, Czech Export Bank, A.S; Agricultural Bank of China, Kazkommertsbank зэрэг олон улсын томоохон банкууд бидэнд итгэл үзүүлэн худалдааны санхүүжилтэд зориулсан зээлийн шугамуудыг нээснээр манай харилцагчид гадаад хямд өртөгтэй санхүүжилтэд хамрагдах боломж улам бүр нээлттэй боллоо.

2006 онд Голомт банк корреспондент банкуудаараа дамжуулан дэлхийн 26 улс руу нийт 120 гаруй аккредитив нээсэн нь өмнөх онтой харьцуулахад 20 хувиар өслөө. Гадаад гүйвуулга, аккредитив, баталгааны үйлчилгээнээс олсон орлого өмнөх онтой харьцуулахад 25 хувиар өссөн байна.



Мөн 186 оронд 140 мянга гаруй цэгээр үйлчилгээ үзүүлдэг хамгийн том мөнгөн шилжүүлгийн Вестерт Юнион сүлжээгээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрээс харилцагчийн мөнгийг хүлээн авч, хүргэж байна. 2006 онд 35 мянга гаруй харилцагчид мөнгөн гүйвуулгын үйлчилгээ үзүүлсэн ба өмнөх онтой харьцуулахад гүйвуулгын дун 20 орчим хувиар өсөж үг гүйвуулгын үйлчилгээнээс 410 сая төгрөгийн орлого олсон байна.

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ТӨСӨВ ТӨЛӨВЛӨГӨӨ, САНХҮҮГИЙН ЗОРИЛТУУДЫН БИЕЛЭЛТ

2006 оны эцэст банкны нийт активын хэмжээ 333,3 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр 352,9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 19.6 тэрбум төгрөгөөр буюу 6,0%-иар давж биелсэн байна.

Активын төлөвлөгөөний биелэлтийг удирддаг гол хүчин зүйл болох татан төвлөрүүлсэн хөрөнгийг 276,2 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 278,6 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 2,3 тэрбум төгрөгөөр буюу 1%-иар давж биеллээ.

Өнгөрөгч онд эх үүсвэрийн төлөвлөгөө биелэгдсэнээр актив эх үүсвэрийн бодлогын хүрээнд тусгагдсан санхүүгийн зорилтууд хангаждаж, хөрөнгө, эх үүсвэрийн өсөлтийн төлөвлөгөө бүхэлдээ биелэгдсэн амжилттай байна.

Салбар, тооцооны төвүүдийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагааны үзүүлэлтийг дотоод үнэлгээний системээр сар бүр дүгнэхийн зэрэгцээ салбар нэгжийн үйл ажиллагааг бүхэлд нь дүгнэх “Scoring system”-ийг нэвтрүүлсэн нь үр дүнгээ өгч өнгөрөгч онд бүх салбар, нэгжүүд төлөвлөгөөгөө биелүүлж ажиллав.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд / сүүлийн 5 жилийг харьцуулснаар /

	Үзүүлэлтүүд	2002	2003	2004	2005	2006
<strong>АКТИВЫН БҮТЦИЙН ХАРЬЦАА</strong>						
1 Нийт актив хадгаламжийн харьцаа		82.1%	81.7%	80.2%	85.2%	<strong>80.5%</strong>
2 Нийт актив хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа		5.1%	6.2%	5.5%	4.9%	<strong>6.2%</strong>
3 Нийт актив цэвэр зээлийн харьцаа		40.8%	41.0%	49.6%	48.2%	<strong>49.6%</strong>
<strong>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</strong>						
4 Зээл хадгаламжийн харьцаа		201.2%	199.2%	161.8%	176.6%	<strong>162.4%</strong>
5 Чанаргүй зээлийн харьцаа		16.8%	9.9%	8.4%	8.6%	<strong>6.7%</strong>
6 Нэг ажилтанд ногдох үйл ажиллагааны дундаж орлого (мян.төг)	41 285	45 780	53 795	59 934	<strong>57 788</strong>	
7 Нэг ажилтанд ногдох ашиг (мян.төг)	3 850	4 020	5 277	5 807	<strong>4 598</strong>	
<strong>АШИГТ АЖИЛЛАГАА</strong>						
8 Активын өгөөж		1.0%	1.0%	1.0%	0.9%	<strong>0.7%</strong>
9 Өөрийн хөрөнгийн өгөөж		14.4%	11.1%	12.0%	11.7%	<strong>8.1%</strong>
10 Цэвэр хүүгийн ахиуц		4.83%	6.81%	5.43%	3.78%	<strong>4.02%</strong>
11 Зардал орлогын харьцаа		46.3%	53.4%	44.9%	45.6%	<strong>53.7%</strong>
12 Цэвэр орлогын харьцаа		9.3%	8.8%	9.8%	9.7%	<strong>8.0%</strong>
<strong>ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</strong>						
13 Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа >= 5%		14.2%	15.4%	13.1%	12.3%	<strong>14.6%</strong>
14 Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа >= 10%		14.2%	15.4%	13.1%	12.3%	<strong>16.7%</strong>
15 Гадаад (нийт) валютын эрсдлийн харьцаа <+-40%		12.8%	27.5%	20.6%	32.4%	<strong>39.7%</strong>
16 Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн өөрийн хөрөнгөд эзлэх хувь <20%		17.6%	11.9%	18.6%	18.3%	<strong>18.3%</strong>
17 Холбогдох этгээдэд /нэг/ олгосон зээлийн өөрийн хөрөнгөд эзлэх хувь <5%		2.7%	1.2%	0.8%	0.1%	<strong>2.0%</strong>
18 Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >=18%		58.5%	57.8%	50.5%	51.7%	<strong>51.7%</strong>
19 Үндсэн хөрөнгийн харьцаа <=8%		2.8%	2.1%	1.4%	1.2%	<strong>1.1%</strong>

## АКТИВЫН ХӨДЛӨЛ ӨӨРЧЛӨЛТ


2006 оны санхүүгийн жилд Голомт банкны нийт актив өмнөх оны мөн үеэс 79.2 тэрбум төгрөгөөр буюу 29 хувиар өсч 352.5 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт хөрөнгийн 50%-ийг зээл, 38%-ийг бусад банк санхүүгийн байгууллагад харилцах, хадгаламж, 4%-ийг үнэт цаас, 6%-ийг бэлэн мөнгө, 1%-ийг үндсэн хөрөнгө, 1%-ийг бусад хөрөнгө хэлбэрээр байршууллаа.

2006 онд цэвэр зээл 2005 оны мөн үетэй харьцуулахад 42.9 тэрбум төгрөгөөр буюу 32.5 хувиар өсч 174.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт активт эзлэх зээлийн хувийг 50 хувиас багагүй байлгах зорилтоо биелүүлж ажиллалаа.




Гадаад актив 23.7 тэрбум төгрөгөөр өсч 99.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт активын 28 хувийг эзэлж байна. Төв банкны болон бусад үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцож 2006 онд нийт 317.3 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдаж авсан бөгөөд 2006 оны эцэст үнэт цаасны үлдэгдэл 15 тэрбум төгрөг байна.


**Нийт актив**




**Цэвэр зээл**



**Үнэт цаасарх хөрөнгө оруулалт**




**Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө**



## ЭХ ҮҮСВЭРИЙН ХӨДЛӨЛ ӨӨРЧЛӨЛТ

2006 оны эцэст нийт эх үүсвэр 2005 оны мөн үетэй харьцуулахад 68.2 тэрбум төгрөгөөр буюу 27 хувиар өсч 321.2 тэрбум төгрөгт хүрлээ. Оны эцсийн байдлаар нийт эх үүсвэрийн 66%-ийг хадгаламж, 21%-ийг харилцах, 7%-ийг бусад банкнаас татсан эх үүсвэр, 3%-ийг бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн эх үүсвэр, 2%-ийг бусад эх үүсвэр тус тус бүрдүүлсэн дүнтэй байна.


Тус санхүүгийн жилд харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хадгаламжийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, хугацааны хувьд олон сонголттой болгосон бөгөөд хадгаламжийн эх үүсвэр 41.5 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт эх үүсвэрийн өсөлтийн 61 хувийг бүрдүүлсэн байна.




Мөн бусад банкнаас татсан эх үүсвэр 12.8 тэрбум төгрөгөөр, санхүүгийн байгууллагаас авсан зээл 3.3 тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

Голомт банк харилцах, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийн өсөлттэй уялдуулан эрсдэл хүлээх чадвараа нэмэгдүүлэх, бэхжүүлэх зорилгоор өнгөрөгч онд дурмийн сангаа 8.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэндээрийн дээр 2.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 31 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 54.4 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

**Харилцах хадгаламж**




**Дүрмийн сан**




## АШИГТ АЖИЛЛАГАА

Өнгөрөгч онд банкны актив ашиглалтын үзүүлэлт хэвээр хадгалагдсан ба оны эцсийн байдлаар нийт активын 76.5% нь орлого олдог хэлбэрээр байршсан байна.

*Зардал орлогын харьцаа*



*Цэвэр хүчгийн ахиуц*



Өөрийн хөрөнгийн өгөөж 8.05%, активын өгөөж 0.71% байгаа нь өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлт боловч банкны үйл ажиллагааны цар хүрээний өсөлт хөгжилтэй харьцуулахад хангалтай үзүүлэлтүүд юм. Өнгөрөгч онд хүүгийн маржин жилийн 4.02 хувь болж өмнөх оныхоос өссөн бөгөөд нэг ажилтанд ноогдох дундаж ашиг 4,6 сая төгрөгтэй тэнцэж байна.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА


Монгол улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын хурдацтай өөрчлөлтүүд, тэр дундаа банк, санхүүгийн системийн хөгжлийн өнөөгийн түвшин нь арилжааны банкуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, бэхжүүлэх, байвал зохих түвшинд нь аваачих шаардлагыг зүйл ёсоор бий болгосоор байна. Зах зээлийн энэхүү шаардлагын үүднээс Голомт банк үр ашигтай эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, түүнийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх, зах зээлийн шаардлага, шалгууруудыг хангаж чадахуйц хэмжээнд хүртэл хөгжүүлэхийг чухалчлан банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч ирлээ. Голомт банкны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны гол зорилтууд нь:

- Үйл ажиллагааны бүхий л хүрээнд эрсдэл, ашигийн оновчтой харьцааг хадгалах;
- Алдагдлыг боломжит хамгийн бага түвшин хүртэл бууруулах;
- Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэлийн хоорондын зөрүүг хамгийн бага түвшинд барих юм.


Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс банкны үйл ажиллагаанд нөлөөлөхүйц томоохон эрсдэлүүд болох зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын болон үйл ажиллагааны эрсдлүүдийн хувьд баримтлах стандартуудыг агуулсан “Эрсдэлийн Удирдлагын Бодлого”-г тодорхойлсон ба энэхүү бодлогын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үүргийг Зээлийн Хороо (зээлийн эрсдэл), Актив Пассивын Хороо (зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэл), Захирлуудын зөвлөл (үйл ажиллагааны эрсдэл) тус тус хариуцан ажиллаж байна.

Голомт банк эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа Базелын Хорооны аргачлал, шалгуур үзүүлэлтуүд болон олон улсын тэргүүлэгч банк, санхүүгийн байгууллагуудын туршлагыг дагаж мөрдөн, баримтлах үндсэн зарчмаа болгосор байна. Мөн бид Монгол банкнаас тогтоосон эрсдэлийн удирдлагын шалгуур үзүүлэлтуүдийг байнга хангасаар ирсэн ба банкны 2006 оны гүйцэтгэл банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангасан үр ашигтай эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо бурдуулж чадсаныг батлан харууллаа.

#### Өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцаа




#### Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



#### Гадаад валютын эрсдэл



#### Нэг зээлдэгчид олгох зээл, өөрийн хөрөнгийн харьцаа



Голомт банкны Санхүүгийн Мэдээлэл Хяналтын газрын Эрсдэлийн Удирдлагын хэлтэс, Зээлийн газар болон Үйлчилгээ Харилцагчийн Газрын Салбар Нэгжийн Удирдлагын хэлтэс хамтран зээлийн эрсдэлийг тогтоосон бодлого, журмын хүрээнд хүрээнд удирдаж, бодлого журмаа нөхцөл байдалд нийцүүлэн сайжруулан хөгжүүлж байна.

#### ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд бид төв банкны шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлсэн өөрийн дотоодод мөрдөгдөх зээлийн эрсдэлийн хэм хэмжээг тогтоон ажиллаж байна. Зээлдэгчдийг зээл, хүүгийн төлбөрөө хугацаа хэтрүүлэх магадлалд нь үндэслэн ялгаатай эрсдэлийн бүлгүүдэд ангилж, бүлэг тус бүрийн нийт зээлийн багцад эзлэх хувь, хэмжээг тодорхой тогтоох зарчим баримталж байна. Бизнес эрхлэгчдийн хувьд өмчлөлийн хэлбэр, зээлийн түүх, бизнесийн болон санхүүгийн чадавхи, бизнесийн хэтийн төлөв зэрэг үзүүлэлтүүдийг зээлийн судалгаанд тулхүү анхаардаг бол засгийн газар, улс төрийн оролцоотой байгууллага иргэд, бусад банкуудын хувьд ялгаатай, илүү нарийвчилсан үзүүлэлтүүдийг ашиглаж байгаа нь үр дүнгээ өгч байна.

Банкны Эрсдэлийн Удирдлагын хэлтэс зээлийн багцын хяналтыг зээлийн бүтээгдэхүүн, эдийн засгийн сектор, харилцагчийн төвлөрөл зэрэг голлох үзүүлэлтүүдээр байнга хийж банкны хүлээгдэж буй ашигт материаллаг нөлөө үзүүлж болохуйц эрсдэлийг урьдчилан илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байна.

Мөн уг хэлтэс зээлдэгчийн бизнесийн орчинд голлон нөлөөлдөг хүчин зүйлүүд болох дотоодын бараа, үйлчилгээний зах зээлийн өөрчлөлт хөдөлгөөн, суурь цалин, өрхийн орлого, эдийн засгийн суурь салбаруудын хэрэглээ, төсвийн орлого, зарлагын судалгааг болон гадаад орчин дахь гэнэтийн өөрчлөлтүүд (stress testing)-ийн нөлөөллийн судалгааг байнга хийж зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг баримталж байна.

Нөгөө талаас, бид банкуудын хэт өрсөлдөөний улмаас үүдэлтэй зээлийн хүүгийн бууралт, банкны системийн зээлийн хэт өсөлт зэрэг системийн хэмжээний сөргө үзэгдлүүдээс үүсч болох эрсдэлүүдийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн анхаарч байна.

### **ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ**

Зах зээлийн эрсдэлийн удирдлага нь хүү, хувьцааны болон гадаад валютын эрсдэлүүдийг багтаадаг. Банкны Актив Пассивын хорооноос зах зээлийн эрсдэлийн хувьд баримтлах стандарт, хязгаарлалтуудыг төв банкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн тодорхойлсон ба эдгээр хязгаарлалтуудын хүрээнд банкны хүү тогтоох болон гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явагдаж байна.

Банк, санхүүгийн зах зээл дэх үнийн өрсөлдөөн саarahгүй улам бүр хүчтэй болсоор байгаагаас банкуудын эх үүсвэрийн өртөг тогтвортой байхад зээлийн хүү буурсаар байх зах зээлийн бус зохиомол үнийн тогтолцоог бий болгож байна. Энэ нь банкуудын цэвэр хүүгийн маржийг бууруулж улмаар ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Банкны системд нэгэnt бий болсон энэхүү гажуудлаас эрсдэл хүлээхгүйн тулд бид хүү төлдөг хөрөнгө, эх үүсвэрийн бүтцэд хувьсах хүүтэй хэсгийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх замаар хөрөнгө, эх үүсвэрийн бүтцийг өөрчлөх гол зарчим баримтлан ажиллаж байна. Ялангуяа зээлийн багцын бүтцэд хувьсах хүүтэй, урт хугацааны зээлүүдийг нэмэгдүүлэх нь ирээдүйд хүүгийн түвшний өөрчлөлтөөс хүлээж болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал нөлөөтэй юм. Бид “Gap and duration” аргачлалаар хүү төлдөг хөрөнгө, эх үүсвэрийн зөрүүг хугацааны янз бүрийн үеүдэд хувааж, ирээдүйн мөнгөн ургалыг таамаглан хүүгийн бодлогодоо ашиглаж байна.

Хөрвөх чадварын удирдлагын хувьд бид төв банкнаас тогтоосон нөөцийн шаардлагыг байнга ханган ажиллаж байгаа ба нөхцөл байдлын шинжилгээ (scenario analyses and simulation)-г янз бүрийн аргачлалуудаар хийж, хадгаламж зээлийн хоршоодын дампуурал гэх мэт зах зээлийн янз бүрийн нөхцөл, гэнэтийн нөлөөллүүдийн үед баримтлах зарчим, хөрвөх чадварын үзүүлэлтүүдийг тодорхойлон ажиллаж байна.

Гадаад валютын эрсдэлийг удирдах үүднээс банкны Актив Пассивын хорооноос олон улсын зах зээлд гадаад валют, алтны арилжаа хийхэд баримтлах стоп лосс лимитүүд болон нээлттэй позицийн хэмжээг тодорхой тогтоож, уг хязгаарлалтын хүрээнд байнгын хяналтыг гүйцэтгэж байна. Бид гадаад валютын хангийн өөрчлөлтөөс хүлээж болзошгүй эрсдэлийг олон улсын банк санхүүгийн системд эрсдлийг хэмжих хамгийн шилдэг арга хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн VaR аргыг ашиглан 99%-н магадлалтайгаар сүүлийн 250 өдрийн арилжааны хангашаар өдөр тутам тооцолж байгаа ба үр дунд нь үндэслэн валютын нээлттэй позицио удирдаж байна. VaR арга зөв ажиллаж буй эсэхийг баталгаажуулах болон зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн нөлөөллөөс үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх зорилгоор улирал тутам Back Testing, Stress Testing хийж ашиглаж буй аргачлалаа баяжуулан ажиллаж байна.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Үйл ажиллагааны эрсдэл нь дотоод үйл явц, хүмүүс, системийн хангалтгүй байдал, алдаа болон гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс үүдэн гардаг. Иймд бид үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд байгууллагын дотоод бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох, шийдвэр гаргах эрх мэдлийг оновчтой хуваарилах, үйл ажиллагааны журам, заавруудыг ойлгомжтой болгох болон улам бүр чухал болсоор байгаа банкны компьютержсэн системуудийн цогц байдлыг хангах, сайжруулах, аюулгүй байдлыг хамгийн дээд заргээр хангах зэрэгт гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Мэдээллийн технологийн аюулгүй байдалд онцгой чухал ач холбогдол өгч банкны үйл ажиллагааны бүхий л түвшинд шинээр хэрэглэгдэх програм, техник хангамжуудыг хэвийн, найдвартай байдал талаас нь төдийгүй нууцлал, аюулгүй байдлын талаас нь тодорхой хугацаанд шалгаж, туршсаны үндсэн дээр нэвтрүүлж байна. Мөн ашиглагдаж буй программ, техник хангамжуудын нууцлал, аюулгүй байдлыг байнга баталгаажуулан ажиллаж байна.

Банкны Ерөнхий Зохицуулалтын газрын Хуулийн хэлтэс нь үйл ажиллагааны бүхий л түвшинд хэрэглэгдэж буй гэрээ, хэлцэл, эрх зүйн баримт бичгүүдийн хуулийн хүчин төгөлдөр байдлыг хангуулах, стандартчилах ажлыг хариуцан гүйцэтгэж ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна.

Мөн бид дотоод хяналтын үйл явцад илэрсэн эрсдэлүүдлийг арилгах, дахин гаргахгүй байх нөхцөл боломжийг бүрдүүлэх үүдиээс холбогдох журам, заавруудыг шинэчлэн сайжруулах, түүний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажиллаж байна.

# БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ Жагсаалт

## ХАРИЛЦАХ ДАНС

- ◆ Иргэдийн
  - ◆ Байгууллагын
  - ◆ Эскроу
  - ◆ Тусгай
- ХАДГАЛАМЖИЙН ДАНС**
- ◆ Хугацаагүй
  - ◆ Хугацаатай
  - ◆ Энгийн хугацаатай хадгаламж
    - 1 сарын хугацаатай
    - 2 сарын хугацаатай
    - 3 сарын хугацаатай
    - 6 сарын хугацаатай
    - 12 сарын хугацаатай
  - ◆ Урьдчилсан хүүт хадгаламж
    - 3 сарын хугацаатай
    - 6 сарын хугацаатай
    - 12 сарын хугацаатай
  - ◆ Хуримтлалын хадгаламж
    - 12 сарын хугацаатай
  - ◆ Хадгаламжийн сертификат
  - Энгийн
  - Купоны
  - Чөлөөтэй хөрвөх
  - ◆ Хөвөгч хүүтэй хадгаламж
  - ◆ Алтан түлхүүр /хүүхдийн/

## КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- ◆ Мастеркарт
  - Алтан карт /дотоодын, олон улсын/
  - Байгууллагын карт /дотоодын, олон улсын/
  - Энгийн карт /дотоодын, олон улсын/
  - Маестро карт /оюутны хөнгөлөлтийн/
  - Кобренд карт
- ◆ Виза карт
  - Алтан карт /дотоодын, олон улсын/
  - Бизнес карт /дотоодын, олон улсын/
  - Классик карт /дотоодын, олон улсын/
  - Виза электрон карт /оюутны хөнгөлөлтийн/
  - Кобренд карт
- ◆ Алтантүрүү юаны карт

## МӨНГӨН ГҮЙВУУЛГА

- ◆ Western Union улс хоорондын мөнгөн гүйвуулга
- ◆ Дотоодын хувийн гүйвуулга
- ◆ Гадаад шилжүүлэг

## ИНТЕРНЕТ БАНК

## ЭЛЕКТРОН БАНК

## ТЕЛЕФОН БАНК

## SMS БАНК

## БИЛЛИНГ

## ЗЭЭЛ

- ◆ Эргэлтийн хөрөнгийн зээл
  - ААН-ийн
  - Иргэдийн
  - Алт олборлолтын
  - ББСБ, ХЗХ-ын
  - Картараар үйлчлэгч байгууллагын
  - Шуурхай зээл
- ◆ Хөрөнгө оруулалтын зээл
- ◆ Шахмал түлшний үйлдвэрлэлийн зээл
- ◆ Бизнесийн жижиг зээл
- ◆ Дахин санхүүжилтийн зээл
- ◆ Импортын зээл
- ◆ Хэрэглээний зээл
  - Ахуйн хэрэглээний
  - Өрхийн
  - Цалингийн
  - Картын инстолмент
  - Хадгаламж барьцаалсан
  - Авто машинны
  - Тэтгэвэрийн зээл
  - Орон сууцны засварын
- ◆ Орон сууцны зээл
  - Азийн Хөгжлийн Банкны
  - Өөрийн эх үүсвэрийн
- ◆ Төслийн зээл
  - Хувийн хэвшлийг хөгжүүлэх
  - Ажлын байр нэмэгдүүлэх
  - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
  - Ногоон зээл
  - Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- ◆ Банк хоорондын зээл
- ◆ Синдикатын зээл

## АККРЕДИТИВ

- ◆ Экспортын
- ◆ Импортын

## БАТАЛГАА

- ◆ Тендерийн баталгаа
- ◆ Банкны баталгаа

## ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА

## ҮНЭТ ЗҮЙЛ ХАДГАЛАХ

## ЧЕК СОЛИХ, ХУДАЛДАХ

- ◆ Нэрийн чек
- ◆ Замын чек

## БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

- ◆ Цүнхээр мөнгө хураах
- ◆ Дансны үлдэгдлийн тодорхойлолт
- ◆ Зээлийн өр төлбөрийн тодорхойлолт
- ◆ Бусад мэдээлэл

# Голомт Банкны Төв, Салбаруудын Хаяг Байршил

## ГОЛОМТ ТӨВ БАНК

Улаанбаатар хот 210620А.  
Сүхбаатарын гудамж. Бодь цамхаг  
Утас: (976-11) 311971, 311530  
Факс: (976-11) 312307, 311958  
Email: mail@golomtbank.com  
Web: http://www.golomtbank.com

### Салбар #1

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг.  
Худалдааны гудамж 6/2  
Утас: (976-11) 310759, 313155  
Факс: (976-11) 326231

### Салбар #2

Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг.  
15-р хороолол, Баяндээл худалдааны төв  
Утас: (976-11) 456980  
Факс: (976-11) 456829

### Салбар #5

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг.  
Бага тойруутийн гудамж  
Утас: (976-11) 320712  
Факс: (976-11) 330436

### Салбар #6

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.  
Насагдоржийн гудамж  
Утас: (976-11) 320814  
Факс: (976-11) 318479

### Салбар #7

Улаанбаатар хот. Сонгинохайрхан  
дүүрэг. 1 дүгээр хороолол  
Утас: (976-11) 681267  
Факс: (976-11) 630347

### Салбар #8

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.  
3 дугаар хороолол, Москва комплекс  
Утас: (976-11) 305419  
Факс: (976-11) 368602

### Салбар #12

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг.  
Энхтайваны өргөн чөлөө.  
Утас: (976-11) 330072  
Факс: (976-11) 330621

### Салбар #14

Орхон аймаг. Баян-Өндөр сум.  
Амарын талбай.  
Утас: (976-01-352) 25200  
Факс: (976-01-352) 25100

### Салбар #15

Дархан уул аймаг. Дархан сум.  
13 дугаар баг.  
Утас, факс: (976-01-372) 27136

### Салбар #16

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.  
Үндсэн хуулийн гудамж. Голомт хотхон.  
Утас, факс: (976-11) 322943

### Тооцооны төв #3

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.  
Чингис хаан нисэх онгоцны буудал.  
Утас, факс: (976-11) 283205

### Тооцооны төв #4

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.  
11-р хороолол. 7-р хороо.  
Утас: (976-11) 350542  
Факс: (976-11) 350544

### Тооцооны төв #9

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.  
Улаанбаатар хотын гаалийн газар  
Утас, факс: (976-11) 242943

### Тооцооны төв #10

Улаанбаатар хот. Багануур дүүрэг.  
Холбооны байр  
Утас: (976-01-21) 22333  
Факс: (976-01-21) 20818

### Тооцооны төв #11

Дорнод аймаг. Хэрлэн сум.  
Утас: (976-01-582) 22703  
Факс: (976-01-582) 22702

### Тооцооны төв #13

Дорноговь аймаг. Замын-Үүд сум.  
Зорчигч үйлчилгээний төв  
Утас, факс: (976-02-5245) 53773

### Тооцооны төв #17

Улаанбаатар хот. Сонгинохайрхан  
дүүрэг. 1 дүгээр хороолол.  
Цамбагарав худалдааны төв.  
Утас: (976-11) 680762  
Факс: (976-11) 680763

### Тооцооны төв #18

Хөвсгөл аймаг. Мөрөн сум. 3-р хороо.  
Утас: (976-01-382) 21462  
Факс: (976-01-382) 21474

### Касс #2

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.  
Энхтайваны өргөн чөлөө 3/1.  
Улаанбаатар зочид буудал.  
Утас: (976-11) 313942

### Касс #3

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.  
Төмөр замчдын гудамж. Туушин тээвэр  
үйлчилгээний цогцолбор  
Утас: (976-11) 34541

### Касс #4

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.  
Тээвэрчийн гудамж. Эрин Интернэшил  
Утас: (976-11) 689612

### Касс #6

Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг.  
Самбуугийн гудамж 46.  
Тэди үйлчилгээний төв.  
Утас: (976-11) 325970

### Касс #7

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг.  
Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв.  
Утас, факс: (976-11) 350267

### Касс #8

Дархан уул аймаг. Дархан сум. 14-р баг.

### Касс #9

Дархан уул аймаг. Дархан сум. 5-р баг.  
Утас, факс: (976-01-372) 35098

### Касс #10

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.  
3-р хороолол. Тамир импекс  
Утас: (976-11) 304959

### Касс #11

Улаанбаатар хот. Баянгол дүүрэг.  
4-р хороолол. Парадокс үйлчилгээний төв  
Утас: (976-11) 301587

### Касс #12

Дорноговь аймаг. Замын-Үүд сум.  
Хилийн шалган навтруулэх байр.  
Утас: (976-01-5245) 53774

### Касс #14

Дорноговь аймаг. Замын-Үүд сум.  
Гаалийн рентген хяналтын талбай

### Касс #15

Дархан уул аймаг.  
Дархан сум. Дулаанхан тосгон.  
Утас: (976-02-362) 40053  
Факс: (976-02-362) 40053

### Касс #16

Орхон аймаг. Баян-Өндөр сум.  
Мобиком.



**Хөндлөнгийн  
Хяналтын тайлан**

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

### Голомт Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

Бид энэхүү тайлангийн 3 - 31 дугаар хуудсанд үзүүлсэн Голомт Банк ХХК-ийн 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангуудад аudit хийж гүйцэтгэлээ.

#### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор Банкны захирлуудын хүлээх үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь Банкны захирлуудын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нэхцэл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залilan, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх байх хариуцлага орно.

#### Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэх аudit дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91 дүгээр эзүйлд заасан хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний үүрэг юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хийж гүйцэтгэсэн аudit дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залilan болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрдслийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нэлэөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нэхцэл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

#### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.



Улаанбаатар, Монгол Улс  
2007 оны 3 дугаар сарын 30

## ГОЛОМТ БАНК ХХК

### 2006 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Тодруулга	2006 мян. төг	2005 мян. төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	<b>3</b>	26,954,740	19,631,673
Хүү болон түүнтэй адилтгах зардал	<b>4</b>	(18,282,530)	(13,283,737)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>8,672,210</b>	<b>6,347,936</b>
Хүүгийн бус орлого	<b>5</b>	4,713,273	4,940,171
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>13,385,483</b>	<b>11,288,107</b>
Үйл ажиллагааны зардал	<b>6</b>	(7,194,547)	(5,141,599)
<b>Үнэ цэнэ бууралтын сангийн өмнөх ашиг</b>		<b>6,190,936</b>	<b>6,146,508</b>
Үнэ цэнэ бууралтын алдагдал	<b>7</b>	(2,562,829)	(2,708,498)
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>3,628,107</b>	<b>3,438,010</b>
Татвар	<b>8</b>	(1,108,565)	(1,057,249)
<b>Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант жилийн ашиг</b>		<b>2,519,542</b>	<b>2,380,761</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

# ГОЛОМТ БАНК ХХК

## 2006 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

	Тодруулга	2006 мян. төг	2005 мян. төг
<b>АКТИВ</b>			
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	<b>9</b>	19,907,641	11,681,078
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	<b>10</b>	134,307,043	102,361,395
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	<b>11</b>	107,919	-
Санхүүгийн хөрөнгө оруулалт	<b>12</b>	14,996,837	19,977,164
Зээл ба урьдчилгаа	<b>13</b>	174,700,230	131,816,896
Бусад актив	<b>14</b>	4,679,112	4,218,936
Үндсэн хөрөнгө	<b>15</b>	3,470,099	3,077,477
Биет бус хөрөнгө	<b>16</b>	304,491	120,337
<b>НИЙТ АКТИВ</b>		352,473,372	273,253,283
<b>ПАССИВ</b>			
Харилцагчдын харилцах, хадгаламж	<b>17</b>	283,706,768	232,837,556
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	<b>18</b>	20,237,532	7,435,989
Монголбанкаас авсан зээл	<b>19</b>	978,421	1,018,101
Засгийн газрын зээл	<b>20</b>	-	500,000
Гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас авсан зээл	<b>21</b>	10,398,490	6,594,358
Бусад өглөг	<b>22</b>	5,427,724	4,386,989
Татварын өглөг		430,371	205,766
<b>НИЙТ ПАССИВ</b>		321,179,306	252,978,759
<b>БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Дүрмийн сан	<b>23</b>	21,934,142	13,434,142
Хуримтлагдсан ашиг		9,359,924	6,840,382
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		31,294,066	20,274,524
<b>НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		352,473,372	273,253,283

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ГОЛОМТ БАНК ХХК

### 2006 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Тодруулга	Дүрмийн сан мян.төг	Хуваарилагдах хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт мян.төг
2005 оны 1 сарын 1-нээр		10,130,726	4,459,621	14,590,347
Тайлант жилийн цэвэр ашиг		-	2,380,761	2,380,761
Тайлант жилд нэмэгдсэн	<b>23</b>	3,303,416	-	3,303,416
2005 оны 12 сарын 31-нээр		13,434,142	6,840,382	20,274,524
Тайлант жилийн цэвэр ашиг		-	2,519,542	2,519,542
Тайлант жилд нэмэгдсэн	<b>23</b>	8,500,000	-	8,500,000
2006 оны 12 сарын 31-нээр		21,934,142	9,359,924	31,294,066

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ГОЛОМТ БАНК ХХК

### 2006 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тодруулга	2006 мян. төг	2005 мян. төг
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>Татварын өмнөх ашиг</b>	3,628,107	3,438,010	
<i>Тохируулга :-</i>			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	636,292	491,844	
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	89,020	49,452	
Данснаас хассан үндсэн хөрөнгө	4,096	1,373	
Үнэ цэнийн бууралтын алдагдал	2,562,829	2,708,498	
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны олз	(22,430)		
Үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит ү.ц-ийн олз	(107,919)	-	
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз/(олз)	1,320	(1,200)	
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг</b>	6,791,315	6,687,977	
<i>Үйл ажиллагааны активын өөрчлөлтүүд:-</i>			
Зээл ба урьдчилгаа	(45,446,163)	(43,559,901)	
Бусад актив	(460,176)	(839,493)	
<i>Үйл ажиллагааны пассивын өөрчлөлтүүд:-</i>			
Харилцагчдын харилцах, хадгаламж	50,869,212	85,712,983	
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	12,801,543	(2,351,880)	
Бусад өглөг	1,040,735	1,949,969	
<b>Үйл ажиллагаанаас орсон бэлэн мөнгө</b>	25,596,466	47,599,655	
Орлогын албан татварын төлөлт	(883,960)	(849,934)	
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	24,712,506	46,749,721	
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Санхүүгийн хөрөнгө оруулалтын цэвэр бууралт/(өсөлт)	5,002,757	(15,449,484)	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	14,804	14,412	
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(1,049,134)	(1,209,702)	
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(273,174)	(44,545)	
<b>Хөрөнгө оруулалтанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ</b>	3,695,253	(16,689,319)	

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

	Тодруулга	2006 мян. төг	2005 мян. төг
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
Дурмийн сангийн өсөлт	8,500,000	3,303,416	
Монголбанкнаас авсан зээл	1,181,670	372,300	
Монголбанкны зээлийн эргэн төлөлт	(1,221,350)	(474,199)	
Засгийн газар ба гадаадын санхүүгийн байгууллагаас авсан зээл	5,626,736	1,876,852	
Засгийн газар, гадаадын болон дотоодын санхүүгийн байгууллагын зээлийн эргэн төлөлт	(2,322,604)	(3,139,726)	
<b>Санхүүгийн үйл ажиллагаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>11,764,452</b>	<b>1,938,643</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт</b>	<b>40,172,211</b>	<b>31,999,045</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>24</b>	<b>114,042,473</b>	<b>82,043,428</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>24</b>	<b>154,214,684</b>	<b>114,042,473</b>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

# ГОЛОМТ БАНК ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА - 2006 ОНЫ 12 САРЫН 31

### 1. БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус Банкны үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 8 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны мөн чанарт томоохон өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дээр үйл ажиллагаагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг албан хаяг нь Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот 210620A, Монгол Улс.

Банкны толгой компани нь Монгол улсад бүртгэлтэй Бодь Интернейшнл ХХК юм.

ТУЗ-ийн 2007 оны 3 сарын 30-ны өдрийн шийдвэрээр Банкны 2006 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн.

### 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

#### 2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Банкны санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангууд нь бодит үнээр хэмжигдсэн үсмэл санхүүгийн хэрэгсэл болон борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр, мянганы орноор тайлагнасан.

#### 2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧЛОО

##### (а) Хүүгийн орлого ба зардал

“Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” эсвэл “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдээс бусад бүх хүйтэй санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг холбогдох санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн үр ашигт хүүгийн хувийг хэрэглэн орлогын тайланд “Хүүгийн орлого” ба “Хүүгийн зардал” гэж хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсноос бусад зээл, урьдчилгааны хүүг аккруэл сууриар орлого, үр дүнгийн тайланда хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн дүнг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

##### (б) Хураамж ба шимтгэлийн орлого

Банкны шимтгэл, хураамжийн орлого ихэвчлэн мөнгөн гүйвуулгын хураамж, зээл олголтын хураамж, дебит болон кредит картын хураамж, харилцах дансны зарлагын шимтгэл ба хадгаламжийн хайрцагны хураамжаас бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь голдуу аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

##### (в) Гадаад валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагаа болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээ анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлан тэнцлийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Ханшины бүх зөрүүг орлого, үр дүнгийн тайланда бүртгэнэ. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

### **(г) Орлогын албан татвар**

Банк нь Монгол Улсын татварын хууль, тогтоомжид заасан татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог.

Тайлан тэнцлийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн дүнгийн хооронд гарах түр зөрүүнд өр төлбөрийн аргыг ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрнө. Үндсэндээ татвар ногдох бүх түр зөрүүнд хойшлогдсон татварын өрийг татвалаас хасагдах бүх түр зөрүү, ашиглагдаагүй татварын хөнгөлөлт ба чөлөөлөлтөнд дараа тооцох татварын авлагыг тэдгээрт харгалзах татвар ногдох ашиг орж ирэх нь тодорхой болсон үед хүлээн зөвшөөрнө. Хэрэв түр зөрүү нь гүүдвил, сөрөг гүүдвил, эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс бий болсон ба нягтлан бодох бүртгэлийн ашиг, татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй бол хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөхгүй.

Тайлан тэнцлийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эсвэл үйлчилж хараахан эхлээгүй байгаа татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно. Өөрийн хөрөнгөд шууд бүртгэх гүйлгээнээс үүссэн (энэ тохиолдолд хойшлогдсон татварыг мөн өөрийн хөрөнгөд шууд бүртгэнэ), эсвэл бизнесийн нэгдэлээс үүссэн (энэ тохиолдолд хойшлогдсон татвар нь үүсэн гүүдвил эсвэл сөрөг гүүдвалийн дунд орно) хойшлогдсон татвалаас бусад бүх хойшлогдсон татварыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

### **(д) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө ба бусад банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах, хадгаламжаас бүрдэнэ.

### **(е) Хөрөнгө оруулалт ба бусад санхүүгийн хөрөнгүүд**

НББОУС 39-ийн хүрээнд санхүүгийн хөрөнгүүдийг “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх”, “Зээл ба авлага”, “Дуусгавар хугацаа хүртэл эзэмших”, “Борлуулахад бэлэн” гэж ангилдаг. Санхүүгийн хөрөнгүүдийг анх бүртгэхдээ бодит үнээр нь, харин “Бодит үнийн өсөлт, бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй хөрөнгө оруулалт”-ын хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлуудыг нэмсэн дүнгээр бүртгэнэ. Банк нь өөрийн санхүүгийн хөрөнгүүдийг анх бүртгэхдээ ангилалыг нь тодорхойлдог.

Санхүүгийн хөрөнгийн бүх хэвийн худалдан авалт, борлуулалтыг арилжаа хийгдсэн өдөр (Банк хөрөнгийг худалдан авах, худалдахыг зөвшөөрсөн өдөр) нь хүлээн зөвшөөрнө. Хэвийн худалдан авалт ба борлуулалт гэдэгт хөрөнгийг тодорхой заасан хугацаа (ерөнхийдөө зах зээл дээр мөрдэж байгаа журам, тогтсон практикийн дагуу тогтоодог)-нд нөгөө талд шилжүүлсэн байхыг шаарддаг худалдан авалт, борлуулалтыг ойлгоно.

### **(и) Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө**

“Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” гэж ангилагдсан санхүүгийн хөрөнгүүд нь “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” санхүүгийн хөрөнгийн ангилалд багтдаг. Хэрэв ойрын хугацаанд борлуулах зорилготойгоор худалдан авсан бол санхүүгийн хөрөнгүүдийг “Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” санхүүгийн хөрөнгө гэж ангилна.

Мөн түүнчлэн “Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа”-аас бусад санхүүгийн хэрэгсэлүүдийг тэдгээр нь тодорхой шалгууруудыг хангасан ба удирдлага энэ ангилалд оруулна гэж шийдсэн тохиолдолд “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” ангилалд оруулна. Нэгэнт энэ ангилалд орсон бол тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд энэ ангилал өөрчлөгдхөн боломжгүй. Энэ ангилалын санхүүгийн хэрэгслийд ба “Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” санхүүгийн хэрэгслийдийг анх бодит үнээр нь хүлээн зөвшөөрөх (гүйлгээний зардлыг орлого, үр дүнгийн тайланд тусгана) ба дараагийн тайлант хугацаанд бодит үнийг нь дахин хэмжинэ. Бодит үнийн өөрчлөлтөөс үүсэн олз, гарзыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

## **2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧЛОО (ҮРГЭЛЖЛЭЛ)**

### **(e) Хөрөнгө оруулалт ба бусад санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)**

#### **(ii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт**

Банк дуусгавар хугацаа хүртэл эзэмших зэрэг хандлагатай ба чадвартай үед, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй, тогтсон дуусгавар хугацаатай үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг “Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө” гэж ангилна. Энэ ангилалд тодорхойгүй хугацаагаар эзэмших хөрөнгө оруулалт орохгүй. Анх хүлээн зөвшөөрсний дараа буюу дараагийн тайлант хугацаанд дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулгыг орлого, үр дүнгийн тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д тусгана. Ийм хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Үнэ цэнийн бууралтын алдагдал”-д багтаана.

#### **(iii) Зээл ба авлага**

Зээл ба авлага нь идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүд юм. Банк нь үүсэх авлагыг дараа нь худалдан борлуулах ямар нэгэн зорилгогүйгээр мөнгийг зээлдэгчид шууд өгөх үед “Зээл ба авлага” бий болно. Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээл ба авлага нь үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэгдэнэ. Хорогдуулгыг орлого, үр тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого” хэсэгт тусгана. Зээл ба авлагын үнэ цэнийн бууралтаас гарсан алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангийн “Үнэ цэнийн бууралтын алдагдал”-д тусгана.

#### **(iv) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө**

“Борлуулахад бэлэн” санхүүгийн хөрөнгөд борлуулах зориулалттай эсвэл өмнөх гурван ангилалын аль нэгэнд багтаагүй үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүд ордог. Анхлан хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг бодит өртгөөр нь хэмждэг ба бодит үнийн зөрүүг тус хөрөнгө оруулалт нь данснаас хасагдах эсвэл үнэ цэнийн бууралтад орох өдөр (энэ өдөр өмнө нь өөрийн хөрөнгөд бүртгэсэн байсан хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ) хүртэлх хугацаанд өөрийн хөрөнгөд тусдаа нэг зүйл болгон бүртгэдэг. Хэрэв дараа тайлангийн үед “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ өссөн ба уг өсөлт нь тус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсний дараах үйл явдалтай бодитойгоор холбоу боломжтой бол үнэ цэнийн бууралтыг орлого, үр дүнгийн тайлангаар дамжуулан буцаана. Орлого, үр дүнгийн тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн өөрийн хөрөнгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын алдагдал нь цаашид шаардлагагүй болсон үед уг алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангаар биш өөрийн хөрөнгө дэх сангаар дамжуулан буцаана.

#### **(ë) Бодит үнэ цэнийн тодорхойлолт**

Зохион байгуулалттай зах зээл дээр идэвхтэй арилжаалагдаж буй санхүүгийн хөрөнгийн бодит үнийг тайлан тэнцлийн өдрийн биржийн хаалтын ханштай харьцуулан тодорхойлно. Идэвхтэй зах зээл байхгүй хөрөнгүүдийн хувьд бодит үнийг үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад танил биш талуудын хооронд хамгийн сүүлд зах зээл дээр хийгдсэн гүйлгээнүүдийг ашиглах, ойролцоо төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэгслийн өнөөгийн зах зээлийн үнийг ашиглах, мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн шинжилгээ, опционы үнэлгээний загвар зэрэг багтана.

#### **(ж) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсоныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны “Алдагдлын тохиолдол”-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг “Алдагдлын тохиолдол” нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн бодитойгоор тооцоолох боломжтой ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

### **(i) Зээл ба урьдчилгаа**

Банк нь зээл ба урьдчилгааны болзошгүй эрсдлийн санг НББОУС 39-д заасны дагуу хүлээн зөвшөөрдөг. НББОУС 39 нь дээрх санг зээл ба урьдчилгааны бүртгэлийн дүн ба анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр тооцохыг шаарддаг. Банкны захирлууд нь Монголбанкны баталж, гаргасан заавар журмуудын дагуу тооцсон эрсдлийн сангийн дүнг, НББОУС 39-ийн дагуу тооцож гаргасан дүнтэй харьцуулж үзсэн ба зөрүү нь материаллаг биш байгааг олж тогтоосон. Тиймээс захирлууд нь НББОУС 39-д нийцвэл Монголбанкны баталж, гаргасан заавар журмууд (эдгээр журмууд нь банкны тодорхой нэг хэвийн зээл ба урьдчилгааны үлдэгдэлд 1 %-иар, чанаргүй зээлийн ангилалд байгаа хугацаанаас нь хамааруулан чанаргүй зээлийн үлдэгдэлд тогтоосон хувиар болзошгүй эрдслийн санг байгуулахыг шаарддаг)-д мөн нийцнэ гэсэн дүгнэлттэй байна.

### **(ii) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт**

Банк нь дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нэг бүр дээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үнэ цэнэ бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба тооцоолсон ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хоёрын зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүн буурах ба алдагдалын дүнг орлого, үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрнө.

Хэрэв дараагийн тайлант жилд тооцоолж байсан үнэ цэнийн бууралтын алдагдлын хэмжээ нь уг үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдлын улмаас буурвал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдалыг “Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал” дансны кредитэд бүртгэнэ.

### **(iii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт**

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсоныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг тайлан тэнцлийн өдөр бүр үнэлж үзнэ.

Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалт нь “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан тохиолдолд бодит нотолгоонд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өөрийн өртгөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал орно. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс өмнө нь орлого үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдалыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч орлого, үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлого, үр дүнгийн тайнгаар дамжуулахгүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг өөрийн хөрөнгөд шууд хүлээн зөвшөөрнө.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хэрэгслийн хувьд түүний үнэ цэнийн бууралтыг хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуур үзүүлэлтүүд дээр суурilan үнэлнэ. Зээлийн буурсан бүртгэлийн дүнгээс анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцон, хүүг үргэлжлүүлэн хуримтлуулах ба “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант жилд өрийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь өссөн ба уг өсөлт нь үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлого, үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрсний дараах тохиолдолтой бодитойгоор холбогдох боломжтой бол, үнэ цэнэ бууралтын алдагдлыг орлого, үр дүнгийн тайлангаар дамжуулан буцаана.

### **(3) Үндсэн хөрөнгө**

Бүх үндсэн хөрөнгийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дунд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль таарамжтай гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа солисон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд орлого, үр дүнгийн тайланда хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илрхийлдэг.

## **2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧЛОО (ҮРГЭЛЖЛЭЛ)**

### **(з) Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)**

Дуусаагүй барилгад элэгдэл байгуулдаггүй. Үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн төрөл бүрээр ашиглалтын жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Эдгээр хөрөнгийн элэгдлийг ашиглалтад орох үеэс нь эхлэн тооцно.

Барилга, байшин	40 жил
Тавилга, тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	5 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл тэдгээрийн ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

### **(и) Биет бус хөрөнгө**

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдалыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь хязгаарлагдмал эсвэл хязгаардагдмал бус байдаг. Хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд эдийн засгийн үр ашигтай ашиглалтын хугацааны турш хорогдуулж, үнэ цэнийн бууралтанд орсон байх магадлалын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг үнэлнэ. Удирдлага хязгаарлагдмал бус хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргачлалыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянаж үздэг. Тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загвар нь өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргыг аль тохиромжтой байдааар өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гэж авч үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг орлого, үр дүнгийн тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн програм хангамж болон лицензүүд багтдаг бөгөөд тэдгээр нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай байна. Эдгээр биет бус хөрөнгийг тэдгээрийн ойролцолон тооцоолсон ашиглалтын хугацаа болох 5 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.

### **(й) Харилцагчдын харилцах, хадгаламж**

Хүлээн авсан харилцах, хадгаламжийг тэдгээрт ирээдүйд төлөх төлбөрийн бодит үнэ болох өртгөөр нь бүртгэнэ.

### **(к) Бусад активын үнэ цэнийн бууралт**

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестижийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүнгээр нь бууруулан бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр дискаунтчилан өнөөгийн үнэ цэнийг олно.

Тайлан тэнцлийн өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл нөхөн төлөгдөх

дүнг ойролцоолон тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Хэрэв тийм бол хөрөнгийн бүртгэлийн дүнг цуглуулан авах дүн хүртэл нь өсгж бүртгэнэ. Энэ өссэн дүн нь хэрэв өмнөх жилүүдэд хөрөнгөд үнэ цэнийн алдагдалыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүн)-гээс хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Ийм буцаалтыг хийсний дараа, хөрөнгийн шинэ бүртгэлийн дүн (улдэгдэл өртгийг хассан дүн)-г түүний ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн зардалд залруулга хийнэ.

**(л) Худалдах, буцаан худалдан авах хэлцлүүд**

Буцаан худалдан авах гэрээтэйгээр (repo) худалдсан үнэт цаасуудыг санхүүгийн тайланд арилжааны эсвэл хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж тусгах ба холбогдох өр төлбөрийг бусад санхүүгийн байгууллагуудад төлөх өр төлбөрийн дүнд багтаан эсвэл аль тохиромжтой байдлаар бүртгэнэ. Дахин худалдах гэрээтэйгээр худалдан авсан үнэт цаасуудыг бусад санхүүгийн байгууллагуудаас авах авлагын дүнд багтаан эсвэл аль тохиромжтой байдлаар бүртгэнэ. Борлуулалт ба худалдан авалтын үнүүдийн хоорондох зөрүүг хүү гэж тооцох ба хүүг repo гэрээний хугацаанд үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хуримтлуулна.

**(м) Санхүүгийн баталгаа**

Банк бизнесийн хэвийн нөхцөлд голдуутендерийн баталгаанаас бүрдэх санхүүгийн баталгаануудыг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайланд анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшуулалын дүнгээр “Бусад өглөг”-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хородгуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг орлого, үр дүнгийн тайлангийн “Үнэ цэнийн бууралтын алдагдал” дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож орлого, үр дүнгийн тайлангийн “Хүүгийн бус орлого” дансанд хүлээн зөвшөөрнө.

**(н) Ажиллагсдын тэтгэмж**

**(i) Богино хугацаат тэтгэмж**

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалzan олгодог, бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог байна.

**(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд**

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын санд шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

**(о) Үйл ажиллагааны түрээс**

Түрээслэгч тал бүх эрсдлийг хүлээж, ашгийг хүртэх үйл ажиллагааны түрээсд төлж байгаа түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож орлого, үр дүнгийн тайланд зардлаар бүртгэнэ.

**(п) Өмчийн хэрэгслүүд**

Дүрмийн санг өөрийн хөрөнгөд ангилах бөгөөд ногдол ашгийг тухайн зарласан үед нь өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

## **2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧЛОО (ҮРГЭЛЖЛЭЛ)**

### **(р) Санхүүгийн өр төлбөрүүд**

Банк нь өөрийн санхүүгийн өр төлбөрүүдийг дараах бүлгүүдэд ангилдаг:

- (i) Бодит үнийн өсөлт, бууралт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх өр төлбөр
- (ii) Арилжааны бус өр төлбөр

Бодит үнийн өсөлт, бууралт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх өр төлбөр гэж ангилагдсан өр төлбөрүүдийг бодит үнээр нь бүртгэх ба бодит үнийн өөрчлөлтөөс үүсэх олз, гарзыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Арилжааны бус өр төлбөрүүдийг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан дүнгээр бүртгэнэ. Гэрээнд заасан үүрэг дууссан, цуцлагдсан эсвэл хугацаа нь өнгөрсөн үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна.

### **(с) Санхүүгийн хэрэгслүүд**

Банк нь санхүүгийн хэрэгслийн гэрээнд холбогдогч тал болсон үед санхүүгийн хэрэгслүүдийг тайлан тэнцэлд тусгана. Эдгээр хэрэгслүүдийг хүлээн зөвшөөрөх болон хэмжихтэй холбогдсон нягтлан бodoх бүртгэлийн бодлогуудыг тэдгээрийн холбогдох нягтлан бodoх бүртгэлийн бодлогод тусгасан болно.

Гэрээнд заасны дагуу санхүүгийн хэрэгслүүдийг өр төлбөр эсвэл өөрийн хөрөнгө гэж ангилна. Өр төлбөр гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслийн холбогдох хүү, ногдол ашиг, олз, гарзыг орлого эсвэл зардал гэж бүртгэнэ. Өөрийн хөрөнгө гэж ангилагдсан санхүүгийн хөрөнгүүдийг эзэмшигчдэд хувиарласан хөрөнгийг шууд өөрийн хөрөнгөд бүртгэнэ. Банк нь цэвэршүүлэн хаах хууль зүйн, хүчин төгөлдөр эрхтэй ба цэвэр дунг төлж барагдуулах эсвэл санхүүгийн хөрөнгөе зарж санхүүгийн өр төлбөрөө барагдуулах төлөвлөгөөтэй байгаа үед санхүүгийн хөрөнгүүдийг цэвэршүүлэн толилуулж болно.

### **(т) Үүсмэл санхүүгийн хэрэгслүүд**

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь гадаад валютын гэрээ болон ханшны форвард гэрээнээс бүрддэг. Деривативүүдийг (үүсмэл санхүүгийн хэрэгслүүд) бодит үнэ цэнээр бүртгэдэг ба бодит үнэ нь зөвхөн байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Хөрөнгийн зах зээлийн үнэ, хямдруулсан мөнгөн хөрөнгийн урсгалын загвар, опшины үнэлгээний загвар зэргийг харгалзаж үзэж, холбодох зохицой бодит үнийг авна. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Хүүгийн бус орлого”-д тусгадаг.

## **2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУДАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД**

Банк нь дараах шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн СТОУС-үүд ба Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хороо (“СТОУТХ”)-ноос гаргасан тайлбаруудыг тайлант хугацаанд дагаж мөрдсөн. Энэ нь 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгө болоод харьцуулсан үзүүлэлтүүдийн өөрчлөлтөд аливаа нөлөө үзүүлэгүй болно.

- \* НББОУС 19 Нэмэлт өөрчлөлт - Актувар олз ба гарз, Бүлгийн төлөвлөгөө ба тодруулга
- \* НББОУС 39 Нэмэлт өөрчлөлт - Ойролцоолсон тооцоололтой дотоод гүйлгээний мөнгөн урсгалын хэджийн НББ
- \* НББОУС 39 Нэмэлт өөрчлөлт - Бодит үнэ цэнийн опцион
- \* НББОУС 39 ба СТОУС 4 Нэмэлт өөрчлөлт - Санхүүгийн баталгааны гэрээнүүд
- \* СТОУС 6 - Эрдэс баялагын хайгуул ба үнэлгээ;
- \* СТОУТХ 4 - Гэрээ нь түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлох.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг батлах өдрийн байдлаар дараах стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь дөнгөж батлагдан гарч байсан ба хэрэгжжих эхлэх болоогүй байсан. Үүнд:

- \* СТОУС 7 - Санхүүгийн хэрэглүүрүүд: Тодруулгууд
- \* НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт - Санхүүгийн тайлангийн толилуулга
- \* СТОУТХ 8 - СТОУС 2-ын үйлчлэх хүрээ
- \* СТОУТХ 9 - Агуулагдсан деривативүүдийн дахин үнэлгээ
- \* СТОУТХ 10 - Хугацааны дундуурх санхүүгийн тайлагнал ба үнэ цэнийн бууралт
- \* СТОУТХ 11 - СТОУС 2 - Бүлэг аж ахуйн нэгж ба халаасны хувьцааны ажил гүйлгээнүүд
- \* СТОУТХ 12 - Үйлчилгээний эрхийн хэлэлцээ

Банкны захирлууд нь ирээдүйд дагаж мөрдөх эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь банкны 2007 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланда материалыг нөлөөлөл үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна. Эдгээр нь нэмэлт тодруулгуудыг хийхийг шаардах болно.

#### **2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД**

Банк нягтлан бодох бүртгэлийн бодлогуудаа мөрдөхийн явцад санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг тодорхойлохдоо өөрийн үнэлэлт болон тооцооллуудыг ашигласан. Ашигласан хамгийн томоохон үнэлэлт болон тооцооллуудыг доор харуулав

##### **(i) Санхүүгийн хэрэгслүүдийн үнэлгээ**

Санхүүгийн тайландаа бүртгэлтэй байгаа санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнийг идэвхтэй зах зээлийн үнээр тодорхойлох боломжгүй үед математик загварчлалуудыг багтаасан үнэлгээний төрөл бүрийн аргыг ашигладаг. Бодит үнэ цэнийг тогтоохын тулд эдгээр загваруудад оруулах өгөдлийг боломжтой бол ажиглаж болохуйц зах зээлээс авдаг. Хэрэв боломжгүй бол тодорхой хэмжээний үнэлэмжийг удирдлагаас шаарддаг. Энэхүү үнэлэмж нь хүлээн авах орлого, деривативүүдийн хоорондын хамаарал (корреляц) болон хэлбэлзэл зэрэг загварт хэрэглэгдэх өгөгдлүүдийг авч үздэг.

##### **(ii) Зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралт**

Банк нь үнэ цэнийн бууралтын санг орлого, үр дүнгийн тайландаа бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс тайлагналын өдөр бүр асуудалтай зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, шаардлагатай сангийн түвшинг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

Дангаараа том дүнтэй зээл ба урьдчилгаанд байгуулсан тусгай сангаас гадна, Банк тусгай сан байгуулах шаардлагатай гэж онцгойлон авч үзээгүй боловч анх олгож байх үеийнхээс зөрчилд өртөх магадлал нь өссөн зээлүүдэд бүлгийн үнэ цэнийн бууралтын санг байгуулдаг. Ингэхдээ тухайн салбарын эрсдэл өссөн эсэх, технологийн хоцрогдолд орсон эсэх, мөн түүнчлэн мөнгөн урсгалд бүтцийн доройтол эсвэл saat алт байгаа эсэх зэрэг олон тооны хүчин зүйлүүдийг харгалзан үздэг.

#### **3. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО**

	<b>2006</b> <b>МЯН. ТӨГ</b>	<b>2005</b> <b>МЯН. ТӨГ</b>
Зээл ба урьдчилгаа	22,480,303	17,043,586
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	3,959,726	1,504,625
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Борлуулахад бэлэн	490,163	1,043,717
Санхүүгийн хөрөнгө оруулалт - Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	24,548	39,745
	<b>26,954,740</b>	<b>19,631,673</b>

#### **4. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ**

	<b>2006</b> <b>МЯН. ТӨГ</b>	<b>2005</b> <b>МЯН. ТӨГ</b>
Харилцагчдын харилцах	601,318	681,190
Харилцагчдын хугацаатай, хугацаагүй хадгаламж	16,810,778	11,766,703
Гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас авсан зээл	638,323	749,355
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	232,111	86,489
	<b>18,282,530</b>	<b>13,283,737</b>

## 5. ХҮҮГИЙН БУС ОРЛОГО

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Шимтгэл хураамжийн орлого:</b>		
Үйлчилгээний шимтгэл, хураамж	1,866,869	1,633,695
Кредит картын хураамж	1,312,204	949,638
Бусад	1,226,588	999,835
	<b>4,405,661</b>	<b>3,583,168</b>
<b>Бусад орлого:</b>		
Гадаад валютын бодит олз	683,533	1,762,439
Гадаад валютын бодит бус гарз	(446,866)	(473,199)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны олз	22,430	-
Үйл ажиллагааны бусад орлого	48,515	67,763
	<b>307,612</b>	<b>1,357,003</b>
<b>Нийт хүүгийн бус орлого</b>	<b>4,713,273</b>	<b>4,940,171</b>

## 6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Зар сурталчилгаа</b>		
Харилцаа холбоо	380,718	360,941
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 15)	636,292	491,844
Биет бус хөрөнгийн хорогдуулалт (Тодруулга 16)	89,020	49,452
Зочин төлөөлөгчийн зардал	21,059	17,314
Үйл ажиллагааны бусад зардал	843,923	566,450
Цалин, холбогдох зардлууд*	1,787,838	1,186,928
Байрны түрээс	1,105,036	842,085
Харуул хамгаалалтын зардал	515,362	204,527
Үйлчилгээний хураамж	1,015,137	692,289
Бичиг хэргийн зардал	263,081	224,050
Томилолтын зардал	256,148	308,818
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз/(олз) (Тодруулга 15)	1,320	(1,200)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 15)	4,096	1,373
	<b>7,194,547</b>	<b>5,141,599</b>

### \*Цалин, холбогдох зардлууд

Цалин, шагнал урамшуулал	1,410,357	939,676
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл	271,250	180,858
Сургалт	94,533	66,394
Тэтгэмж	11,698	-
	<b>1,787,838</b>	<b>1,186,928</b>

## 7. ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДАЛ

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Зээл ба урьдчилгаа</b>		
Санхүүгийн хөрөнгө оруулалт	-	22,430
	<b>2,562,829</b>	<b>2,708,498</b>

## 8. ТАТВАР

	2006 мян. төг	2005 мян. төг
Тайлант жилийн үр дүнд ногдох орлогын татвар	1,108,565	1,057,249

Банк нь санхүүгийн тайлант орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 100 сая төгрөг хүртэл ашгаас 15% (2005 : 15%)-ийн, 100 саяас дээш төгрөгийн ашгаас 30% (2005 : 30%)-ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн газрын бондын хүүгийн орлогод татвар тооцохгүй. Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлаас хамгаалах сан нь татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцогдоно.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2006 мян. төг	2005 мян. төг
Татварын өмнөх ашиг	3,628,107	3,438,010
Орлогын албан татварын хэмжээ 30% (2005 онд: 30%)	1,088,432	1,031,403
Татвараас чөлөөлөгддөг орлого	(7,365)	(11,923)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	42,498	52,769
Бага хувиар (15 %) татвар ногдох орлого	(15,000)	(15,000)
Тайлант жилийн татварын зардал	1,108,565	1,057,249

Түр зөрүү гараагүй тул тайлант хугацааны ба өмнөх жилүүдийн тайланд хойшлогдсон татварыг тусгаагүй болно.

Банк нь өөрийн үйл ажиллагаанд хамаарах татварын хуулиудад заасны дагуу татвараа төлж буй гэж Банкны удирдлага үзэж байна.

## 9. БЭЛЭН МӨНГӨ, БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ

	2006 мян. төг	2005 мян. төг
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө:		
Төгрөгөөр	8,375,454	4,655,698
Валютаар	11,532,187	7,025,380
	<b>19,907,641</b>	<b>11,681,078</b>

Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгөтэй холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## 10. БУСАД БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2006 мян. төг	2005 мян. төг
Монголбанкин дахь харилцах	20,222,530	18,890,823
Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	114,084,513	83,470,572
	<b>134,307,043</b>	<b>102,361,395</b>

Монголбанкаас тавигддаг шаардлагын дагуу хөрөнгийг Монголбанкинд байршуулдаг бөгөөд дансны үлдэгдэлд хувь тооцдоггүй. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний үлдэгдлийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15 хоногийн дундаж дээр үндэслэн тодорхой тогтоосон хувиар бодож гаргадаг.

## **10. БУСАД БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)**

Тодруулга 21-т дурьдсанчлан, 39.24 сая төгрөг (2005 онд 37.05 сая төгрөг)-ийн Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийг зээлийн барьцаанд тавьсан байна.

Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжтай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## **11. ҮУСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД**

Доорх мэдээллийг хөрөнгө болон өр төлбөрөөр бүртгэсэн үүсмэл санхүүгийн хэрэслүүдийн бодит үнийг нэрлэсэн дүнгийн хамт толилуулсан байна. Нэрлэсэн дун нь (энэ нь нийт дүнгээр бүртгэгдсэн) үүсмэл санхүүгийн хэрэгслийн салшгүй хамааралтай хөрөнгийн дун байдаг бөгөөд үүсмэл санхүүгийн хэрэгслийнх нь бодит үнийг энэхүү хөрөнгөд үндэслэн хэмждэг. Нэрлэсэн дун нь ажил гүйлгээний жилийн эцсийн үлдэгдлийг харуулдаг ба зах зээлийн болон зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлээгүй болно.

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа дериватив гадаад валютын</b>		
<b>форвард гэрээнүүд</b>		
Хөрөнгө	107,919	-
Өр төлбөр	-	-
Нэрлэсэн дун	<b>264,147,372</b>	-

2006 оны 12-р сарын 31-ний байдлаар, гадаад валютын форвард гэрээнүүд нь харилцагч нартай хийсэн, талуудын хооронд дуусах хэлцэлүүдтэй холбоотой байсан.

Үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## **12. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Борлуулахад бэлэн:</b>		
Бодит үнэ цэнээр бүртгэсэн Монголбанкны үнэт цаас	14,995,837	17,746,082
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй ба өртгөөр нь бүртгэсэн		
өөрийн хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалт	1,000	-
	14,996,837	17,746,082
<b>Дуусгавар хугацаа хүртэл эзэмших:</b>		
Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн авлагын бичиг	-	2,253,512
Үнэ цэнэ бууралтын сан	-	(22,430)
	-	2,231,082
	<b>14,996,837</b>	<b>19,977,164</b>

Монголбанкны үнэт цаас нь гурван сар болон түүнээс доош хугацаатай богино хугацааны, хүү тооцдог үнэт цаас байдааг бөгөөд тэдгээрийг бодит үнээс нь хямдруулсан нөхцөлтэйгээр гаргадаг. 2005 онд векселийг хувийн компаниуд 180 - 300 хоног хүртэлх хугацаатайгаар гаргасан.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй ба өөрийн хөрөнгөд хийсэн хөрөнгө оруулалт нь Монголын Ипотекийн Корпорацид хийсэн хөрөнгө оруулалт юм. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй зах зээлийн үнэ нь байхгүй ба үнэлгээний аргачлалуудаар энэхүү хэрэгслийн бодит үнийг найдвартайгаар тогтоох боломжгүй тул өртгөөр нь бүртгэсэн болно.

Санхүүгийн хөрөнгө оруулалттай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

### 13. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

	2006 мян. төг	2005 мян. төг
Хугацаат зээл	182,996,231	134,099,855
Төслийн зээл	804,485	6,091,921
Картын зээл	1,877,601	379,251
Ажилчдад олгосон зээл	393,623	468,863
Хуримтлагдсан хүүгийн авлага	966,144	1,356,472
Нийт зээл ба урьдчилгаа	187,038,084	142,396,362
Үнэ цэнэ бууралтын сан		
- тусгай сан	(11,560,165)	(8,766,491)
- бүлгийн сан	(777,689)	(1,812,975)
<b>Зээл ба урьдчилгааны цэвэр дүн</b>	<b>174,700,230</b>	<b>131,816,896</b>

Нийт зээл ба урьдчилгааг тэдгээрийн эдийн засгийн зориулалтаар нь ангилан үзүүлбэл:

	2006 мян. төг	2005 мян. төг
Худалдаа	77,506,275	37,719,460
Боловсруулах салбар	30,852,066	36,581,216
Уул уурхай	12,987,499	16,667,479
Барилга, тээвэр	9,921,933	7,714,706
Цахилгаан, түлш, ус ханган нийлүүлэх салбар	1,638,151	6,570,819
Зочид буудал, ресторан	1,694,059	8,164,396
Тээвэр, холбоо	7,190,638	4,887,566
Түрээс	12,080,487	7,160,910
Эрүүл мэнд, боловсрол	3,663,116	2,228,914
Банк хоорондын зээл	1,956,756	6,933,020
Хөдөө аж ахуй	5,728,239	965,599
Бусад	21,818,865	6,802,277
<b>Зээл ба урьдчилгаанд нийт чанаргүй зээлийн эзлэх хувь</b>	<b>187,038,084</b>	<b>142,396,362</b>

Монголбанкны заавар, журмуудын дагуу, хүү болон үндсэн зээлийн төлбөрийг 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрүүлсэн тохиолдолд зээлийг “Чанаргүй Зээл” гэж ангилдаг. Чанаргүй зээлийн дэлгэрэнгүй мэдээллийг дор харуулвал:

	2006 мян. төг	2005 мян. төг
Жилийн эцсийн үлдэгдэл	12,450,557	12,239,589
Хасах нь: Үнэ цэнэ бууралтын алдагдлын сан	(10,971,335)	(8,720,110)
Жилийн эцсийн цэвэр үлдэгдэл	1,479,222	3,519,479
<b>Нийт зээл ба урьдчилгаанд нийт чанаргүй зээлийн эзлэх хувь</b>	<b>6.66%</b>	<b>8.60%</b>
<b>Цэвэр зээл ба урьдчилгаанд цэвэр чанаргүй зээлийн эзлэх хувь</b>	<b>0.85%</b>	<b>2.67%</b>

Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг дор үзүүлэв:

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Тусгай сан</b>		
Жилийн эхний үлдэгдэл	8,766,491	6,971,125
Тайлант жилд нэмж байгуулсан	4,788,386	3,949,112
Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн	(1,205,017)	(2,035,906)
Данснаас хассан	(781,800)	-
Ханшны зөрүү	(7,895)	(117,840)
<b>Жилийн эцсийн үлдэгдэл</b>	<b>11,560,165</b>	<b>8,766,491</b>

### 13. ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Бүлгийн сан</b>		
Жилийн эхний үлдэгдэл	1,812,975	1,038,519
Тайлант жилд нэмж байгуулсан	480,710	1,391,514
Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн	(1,501,250)	(618,652)
Ханшны зөрүү	(14,746)	1,594
Жилийн эцсийн үлдэгдэл	<b>777,689</b>	<b>1,812,975</b>

Эдийн засгийн өнөөгийн болоод цаашдын нөхцөл байдлын талаарх өөрсдийн мэдлэг дээр тулгуурлан хийсэн өөрсдийн зээлийн хяналт, дүн шинжилгээнүүд дээр үндэслэн тус банкны удирдлага нь байгуулсан үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хэмжээг зохистой гэж үзэж байна.

Зээл ба урьдчилгаатай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

### 14. БУСАД АКТИВ

	2006 мян. төг	2005 мян. төг
Бусад актив	1,304,848	1,726,917
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	-	(12,281)
	1,304,848	1,714,636
Урьдчилж төлсөн зардал	3,065,234	2,288,140
Хангамжийн ба бусад материал	309,030	216,160
	<b>4,679,112</b>	<b>4,218,936</b>

Бусад активтай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

### 15. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

2006 оны 12 сарын 31	Барилга байшин мян.төг	Түрээсийн байрны засвар мян.төг	Тавилга, эд хогшил, тээврийн хэрэгсэл мян.төг		Дүн мян.төг
			Хоригийн байшин мян.төг	Хоригийн байрны засвар мян.төг	
<b>Өртгөөр</b>					
2006 оны 1-р сарын 1-нээр	1,238,443	30,538	3,534,774	4,803,755	
Нэмэгдсэн	22,908	-	1,026,226	1,049,134	
Худалдан борлуулсан	-	-	(50,414)	(50,414)	
Данснаас хассан (Тодруулга 6)	-	-	(81,534)	(81,534)	
2006 оны 12-р сарын 31-нээр	1,261,351	30,538	4,429,052	5,720,941	
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>					
2006 оны 1-р сарын 1-нээр	173,804	19,001	1,533,473	1,726,278	
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 6)	63,129	3,053	570,110	636,292	
Худалдан борлуулсан	-	-	(34,290)	(34,290)	
Данснаас хассан (Тодруулга 6)	-	-	(77,438)	(77,438)	
2006 оны 12-р сарын 31-нээр	236,933	22,054	1,991,855	2,250,842	
<b>Дансны үнэ /цэвэр/</b>	<b>1,024,418</b>	<b>8,484</b>	<b>2,437,197</b>	<b>3,470,099</b>	

2005 оны 12 сарын 31	Барилга байшин мян.төг	Түрээсийн байрны засвар мян.төг	Тавилга, эд хогшил, тээврийн хэрэгсэл мян.төг	Дүн мян.төг
<b>Өртгөөр</b>				
2005 оны 1-р сарын 1-нээр	815,558	30,538	2,861,314	3,707,410
Нэмэгдсэн	422,885	-	786,817	1,209,702
Худалдан борлуулсан	-	-	(48,207)	(48,207)
Данснаас хассан (Тодруулга 6)	-	-	(65,150)	(65,150)
2005 оны 12-р сарын 31-нээр	1,238,443	30,538	3,534,774	4,803,755
<b>Хуримтлагдсан элэгдэл</b>				
2005 оны 1-р сарын 1-нээр	132,106	15,948	1,185,152	1,333,206
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 6)	41,698	3,053	447,093	491,844
Худалдан борлуулсан	-	-	(34,995)	(34,995)
Данснаас хассан (Тодруулга 6)	-	-	(63,777)	(63,777)
2005 оны 12-р сарын 31-нээр	173,804	19,001	1,533,473	1,726,278
<b>Дансны үнэ /цэвэр/</b>	<b>1,064,639</b>	<b>11,537</b>	<b>2,001,301</b>	<b>3,077,477</b>

## 16. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	Програм хангамж, лиценз	
	2006 мян. төг	2005 мян. төг
<b>Өртгөөр</b>		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	276,319	231,774
Нэмэгдсэн	273,174	44,545
12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	549,493	276,319
<b>Хуримтлагдсан хорогдуулалт</b>		
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	155,982	106,530
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 6)	89,020	49,452
12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	245,002	155,982
<b>Дансны цэвэр үнэ</b>	<b>304,491</b>	<b>120,337</b>

## 17. ХАРИЛЦАГЧДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2006 мян. төг	2005 мян. төг
Харилцах данс	61,901,109	61,482,162
Хугацаагүй хадгаламж	72,090,958	58,108,546
Хугацаатай хадгаламж	115,442,772	97,796,708
Төсвийн байгууллагын харилцах, хадгаламж	22,419,829	11,969,794
Бусад харилцах, хадгаламж	11,852,100	3,480,346
	<b>283,706,768</b>	<b>232,837,556</b>

Харилцагчдын харилцах, хадгаламжтай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## **18. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ**

	<b>2006</b> <b>мян. төг</b>	<b>2005</b> <b>мян. төг</b>
Валютын харилцах, хадгаламж	10,624,934	5,502,785
Төгрөгийн харилцах, хадгаламж	9,612,598	1,933,204
	<b>20,237,532</b>	<b>7,435,989</b>

Дотоодын арилжааны банкнууд гадаад валютын болон төгрөгийн харилцах болон хадгаламжийн дансдуудыг байршуулдаг.

Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжтай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## **19. МОНГОЛБАНКНААС АВСАН ЗЭЭЛ**

	<b>2006</b> <b>мян. төг</b>	<b>2005</b> <b>мян. төг</b>
<b>Барьцаагүй:</b>		
Монгол банкнаас авсан зээл	978,421	1,018,101

Эдгээр зээлд жилийн 10% (2005 онд 10%) хүү төлдөг. Эргэн төлөх хуваарийн дагуу 2005 оны 7-р сард төлж барагдуулах ёстой байсан ч зээлийн хугацааг сунгуулснаар 2007 оны 6-р сард дуусах нөхцөлтэй болсон.

Монголбанкнаас авсан зээлтэй холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## **20. ЗАСГИЙН ГАЗРЫН ЗЭЭЛ**

	<b>2006</b> <b>мян. төг</b>	<b>2005</b> <b>мян. төг</b>
<b>Барьцаагүй:</b>		
Засгийн газрын зээл	-	500,000

Зээлийн хүүгийн хувь нь 2005 онд, жилийн тогтмол 6% байсан. Тайлант жилд зээлийг төлж дууссан.

Засгийн Газрын зээлтэй холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

## **21. ГАДААДЫН, ДОТООДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ**

	<b>2006</b> <b>мян. төг</b>	<b>2005</b> <b>мян. төг</b>
<b>Барьцаатай:</b>		
Берлинер Банкны Зээл	479,931	464,349
<b>Барьцаагүй:</b>		
Дэлхийн Банкны Зээл I	1,141,952	2,142,472
Дэлхийн Банкны Зээл II	778,878	1,307,248
Дэлхийн Банкны Зээл III	336,615	385,355
Азийн Хөгжлийн Банкны Зээл	3,161,114	2,294,934
Монгол Шуудан Банкнаас авсан хоёрдогч өглөгөөрх зээл	4,500,000	-
	<b>9,918,559</b>	<b>6,130,009</b>
<b>Нийт дүн</b>	<b>10,398,490</b>	<b>6,594,358</b>

### **Берлинер Банкны Зээл**

Берлинер Банкны зээлийг Герман улсад барилга худалдаж авахад ашигласан. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 7.45% - 8.87% (2005 онд 7.45%) байсан. Банк нь 1996 оны 6 дугаар сараас эхлэн зээлийн эргэн төлөлтийг улирал бүр хийж эхэлсэн ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2025 оны 9 дүгээр сар. Тодруулга 10-т заасаны дагуу зээлийн барьцаанд бусад

банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийг тавьсан байна.

#### **Дэлхийн Банкны Зээл I**

Дэлхийн Банкны энэ зээлийг “Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээлийн хөтөлбөр”-ийн хүрээнд төрөл бүрийн зээлдэгчдэд олгодог. Дэлхийн Банкны зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 7.63%-8.42% (2005 онд 5.63%-7.63%) байсан. Зээлийн эргэн төлөлт нь төрөл бүрийн эргэн төлөлтийн хуваариудын дагуу хийгддэг ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2010 оны 3 дугаар сар.

#### **Дэлхийн Банкны Зээл II**

Дэлхийн Банкны энэ зээлийг “Хувийн хэвшлийг хөгжүүлэх зээлийн хөтөлбөр”-ийн хүрээнд төрөл бүрийн зээлдэгчдэд олгодог. Дэлхийн Банкны зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 7.46% - 9.81% (2005 онд 9.13%-15.96% ) байсан. Зээлийн эргэн төлөлт нь төрөл бүрийн эргэн төлөлтийн хуваариудын дагуу хийгддэг ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2009 оны 6 дугаар сар.

#### **Дэлхийн Банкны Зээл III**

Энэ зээл нь банкны ажилчдын сургалтанд зориулагдсан ба жилийн 2%-ийн тогтмол хүйтэй (2005 онд 2% байсан). Эргэн төлөлтийн хуваарийн дагуу үндсэн төлбөрийг 2004 оны 11 дүгээр сараас эхлэн хагас жил тутамд төлөх ба эцсийн төлбөр хийх хугацаа нь 2019 оны 5 дугаар сар.

Азийн Хөгжлийн Банкны Зээл

Энэ зээлийг орон сууцны зээл хүсэгчдэд олгосон. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 8.13%-8.29% (2005 онд 7.9%-8.2% ) байна. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа төрөл бүрийн эргэн төлөлтийн хуваариудын дагуу байна.

#### **Монгол Шуудан Банк ХХК**

Хоёрдогч өглөгийг ажлын капиталын зорилгоор авсан. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь жилийн 13% байна. Зээлийн төлбөрийг бухлээр нь хийх ба төлбөр хийх хугацаа нь 2011 оны 12 дугаар сар юм.

Тайлант хугацаанд Банк нь өөрийн хүлээсэн үргийн дагуу үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг цаг хугацаанд нь гүйцэтгэж байсан ба аливаа нэг зөрчил гаргаагүй болно.

Гадаадын, дотоодын банкуудаас авсан зээлтэй холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

#### **22. БУСАД ПАССИВ**

	2006 мян. төг	2005 мян. төг
Өглөг	3,862,371	3,200,917
Гадаад гүйвуулга	220,137	161,095
Клирингийн saatал	1,319,758	1,020,884
Бусад өглөг	25,458	4,093
	<b>5,427,724</b>	<b>4,386,989</b>

Бусад пассивтай холбоотой санхүүгийн эрсдэлийн талаарх бусад мэдээллийг Тодруулга 25-т тусгасан болно.

#### **23. ДҮРМИЙН САН**

	2006 мян. төг	2005 мян. төг
1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар	13,434,142	10,130,726
Тайлант жилд нэмэгдсэн	8,500,000	3,303,416
12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар	<b>21,934,142</b>	<b>13,434,142</b>

Тайлант жилд Банкны дүрмийн сан Монголбанкны баталсны дагуу 13.43 тэрбум төгрөгөөс 21.93 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

## 24. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2006 мян. төг	2005 мян. төг
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	19,907,641	11,681,078
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	134,307,043	102,361,395
	<b>154,214,684</b>	<b>114,042,473</b>

## 25. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Эрсдлийн удирдлага нь Банкны бизнесийн гол тулгуур бөгөөд банкны үйл ажиллагааны салшгүй хэсэг байна. Банкны үйл ажиллагаанд учирдаг гол эрсдлүүдэд зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, хүүгийн хувийн хөдөлгөөн, гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэл багтдаг. Эдгээр эрсдлүүдэд хамаарах банкны эрсдлийн менежментийн бодлогыг дор тайлбарлав.

### Зээлийн эрсдэл

Харилцагч тал төлбөрөө хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүйгээс зээлийн эрсдэл үүсдэг. Банк нь тухайн нэг зээлдэгч, бүлэг зээлдэгч, үйлдвэрлэгчид тус бүрээр хүлээн зөвшөөрч болох эрсдлийн хэмжээнд хязгаар тогтоон эрсдлийн түвшинг зохицуулдаг. Ийм эрсдлийг эргэлтийнх нь байдлаар дүн шинжилгээ хийж, жилдээ нэг буюу түүнээс дээш удаа хяналт шалгалаа явуулдаг. Зээлийн эрсдлийн түвшинд тогтоосон хязгаарыг зээлдэгч тус бүрээр болон бүтээгдэхүүн тус бүрээр банкны удирдлага тогтмол баталдаг.

Үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн чадварыг байнга судалж, шинжлэх ба шаардлагатай бол зээл олголтын хязгаарыг өөрчлөх замаар тулгарч болзошгүй зээлийн эрсдлийг зохицуулдаг. Мөн үүний зэрэгцээ барьцаа хөрөнгө авах аргаар зээлийн эрсдлийг бууруулдаг.

Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 99.3 тэрбум төгрөг (2005 онд 75.6 тэрбум төгрөг байсан), 461 сая төгрөгийн үндсэн хөрөнгө (2005 онд 476 тэрбум)-өөс бусад хөрөнгө, өр төлбөр нь газар зүйн хувьд Монгол Улсад төвлөрч байна.

### Зээлтэй холбоотой санхүүгийн үүрэг

Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь харилцагчийн анхны шаардлагаар эх үүсвэрээр тэр даруй найдвартайгаар хангахад оршидог. Баталгаа ба нээлттэй аккредитивууд нь харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлашгүй үүрэг хүлээсэнийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгсэлийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил байдаг.

### Валютын ханшны эрсдэл

Банкны санхүүгийн байдал болон мөнгөн урсгалд нөлөөлөх валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлд банк өртөмтгийг байдаг. Банкны удирдлага хүлээж болох эрсдлийн түвшинд валют тус бүр дээр (голдуу ам.доллар дээр) болон бүхэлд нь хязгаар тогтоож өгдөг. Банкны 12-р сарын 31-нээрх валютын ханшны эрсдэлд өртөх байдлыг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Банкны актив, пассивыг валютаар нь үзүүлэв:

	Гадаад валютаар				
	Төгрөг	Ам. доллар	Евро	Бусад	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
<b>2006 оны 12 сарын 31</b>					
<b>Актив</b>					
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	8,375,454	5,181,998	749,511	5,600,678	19,907,641
Бусад банк, санхүүгийн байгууллага					
дахь харилцах, хадгаламж	20,505,241	101,997,262	6,137,143	5,667,397	134,307,043
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	-	7,171	-	100,748	107,919
Санхүүгийн хөрөнгө оруулалт	14,996,837	-	-	-	14,996,837
Зээл ба урьдчилгаа	60,085,883	112,882,959	1,186,745	544,643	174,700,230
Бусад актив-бусад авлага	855,618	444,100	-	5,130	1,304,848
	104,819,033	220,513,490	8,073,399	11,918,596	345,324,518
<b>Пассив</b>					
Харилцагчдын харилцах, хадгаламж	128,812,365	140,641,729	4,114,383	10,138,291	283,706,768
Бусад банк, санхүүгийн байгууллагын					
харилцах, хадгаламж	9,612,599	10,331,741	16,854	276,338	20,237,532
Монголбанкаас авсан зээл	978,421	-	-	-	978,421
Гадаад, дотоодын санхүүгийн					
байгууллагаас авсан зээл	8,439,991	1,478,568	479,931	-	10,398,490
Бусад пассив	1,062,750	4,210,598	80,113	74,263	5,427,724
	<b>148,906,126</b>	<b>156,662,636</b>	<b>4,691,281</b>	<b>10,488,892</b>	<b>320,748,935</b>
Цэвэр позиц	(44,087,093)	63,850,854	3,382,118	1,429,704	24,575,583

Банкны актив, пассивыг валютаар нь үзүүлэв:

	Гадаад валютаар				
	Төгрөг	Ам. доллар	Евро	Бусад	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
<b>2005 оны 12 сарын 31</b>					
<b>Актив</b>					
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	4,655,698	3,478,871	744,898	2,801,611	11,681,078
Бусад банк, санхүүгийн байгууллага					
дахь харилцах, хадгаламж	12,895,347	69,216,253	8,079,100	12,170,695	102,361,395
Санхүүгийн хөрөнгө оруулалт	17,746,082	2,231,082	-	-	19,977,164
Зээл ба урьдчилгаа	35,127,264	96,476,420	107,301	105,911	131,816,896
Бусад актив-бусад авлага	407,468	675,361	36	631,771	1,714,636
	70,831,859	172,077,987	8,931,335	15,709,988	267,551,169
<b>Пассив</b>					
Харилцагчдын харилцах, хадгаламж	79,465,549	140,365,764	6,735,301	6,270,942	232,837,556
Бусад банк, санхүүгийн байгууллагын					
харилцах, хадгаламж	5,502,785	900,633	765,331	267,240	7,435,989
Монголбанкаас авсан зээл	1,018,101	-	-	-	1,018,101
Засгийн газрын зээл	500,000	-	-	-	500,000
Гадаад, дотоодын санхүүгийн					
байгууллагаас авсан зээл	3,602,182	2,527,827	464,349	-	6,594,358
Бусад пассив	602,780	3,508,889	112,444	162,876	4,386,989
	<b>90,691,397</b>	<b>147,303,113</b>	<b>8,077,425</b>	<b>6,701,058</b>	<b>252,772,993</b>
Цэвэр позиц	(19,859,538)	24,774,874	853,910	9,008,930	14,778,176

## 25. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Төлбөрийн чадварын эрсдэл

Банк төлбөрийн чадварын эрсдэлд өртдөг. Энэ нь Банк хэвийн болон хугацаа нь тулсан нөхцөлд төлбөрийн үүргээ гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл юм. Банкны Актив пассивын удирдлагын хороо нь хүрэлцэхүйц хэмжээний мөнгийг бэлэн байлгахын тулд хугацаа нь дуусч буй эх үүсвэрийн доод хэмжээнд хязгаар тогтоохын зэрэгцээ гэнэтийн их хэмжээний гүйлгээ хийхэд хөрөнгийг бэлэн байлгах үүднээс банк хоорондын ба бусад өрийн хэрэгслийн хамгийн доод хэмжээг тогтоодог. Банкны актив, пассивыг тайлан тэнцлийн өдрөөс гэрээт хугацаа хүртэлх хугацаагаар нь бүлэглэн дүн шинжилгээ хийснийг дараах хүснэгтэд үзүүлэв.

2006 оны 12-р сарын 31-ний байдлаарх Банкны актив, пассивыг гэрээт хугацаагаар нь дор үзүүлэв (сая. төгрөг):

	<b>3 хүртэлх cap</b>	<b>6 сараас 1 жил</b>	<b>5 жилээс дэш</b>	<b>Нийт</b>
<b>Актив</b>				
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	19,907,641	-	-	19,907,641
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	111,989,895	17,777,900	-	4,500,000 39,248 134,307,043
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	107,919	-	-	107,919
Санхүүгийн хөрөнгө оруулалт	14,995,837	-	-	1,000 - 14,996,837
Зээл ба урьдчилгаа	56,570,033	29,915,524	44,746,350 41,287,696	2,180,627 174,700,230
Бусад актив-бусад авлага	1,202,310	5,073	97,465	- - 1,304,848
	<b>204,773,635</b>	<b>47,698,497</b>	<b>44,843,815</b>	<b>45,788,696</b>
				<b>2,219,875 345,324,518</b>
<b>Пассив</b>				
Харилцагчдын харилцах, хадгаламж	219,740,169	33,464,323	30,433,692	68,584 - 283,706,768
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	19,206,572	1,000,000	30,960	- - 20,237,532
Монголбанкаас авсан зээл	141,931	335,447	414,539	86,504 - 978,421
Гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас авсан зээл	359,773	317,515	556,384	7,098,744 2,066,074 10,398,490
Бусад пассив	5,290,459	125,464	11,801	- - 5,427,724
	<b>244,738,904</b>	<b>35,242,749</b>	<b>31,447,376</b>	<b>7,253,832</b>
				<b>2,066,074 320,748,935</b>
<b>Цэвэр позиц</b>	<b>(39,965,269)</b>	<b>12,455,748</b>	<b>13,396,439</b>	<b>38,534,864</b>
<b>Зэрүү</b>	<b>(39,965,269)</b>	<b>(27,509,521)</b>	<b>(14,113,082)</b>	<b>24,421,782</b>
				<b>24,575,583</b>

2005 оны 12-р сарын 31-ний байдлаарх Банкны актив, пассивыг гэрээт хугацаагаар нь дор үзүүлэв (сая. төгрөг):

	<b>3 хүртэлх cap</b>	<b>6 сараас 1 жил</b>	<b>5 жилээс дээш</b>	<b>Нийт</b>
<b>Актив</b>				
Бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө	11,681,078	-	-	11,681,078
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	83,398,849	16,483,500	2,442,000	37,046 102,361,395
Санхүүгийн хөрөнгө оруулалт	19,460,010	517,154	-	- 19,977,164
Зээл ба урьдчилгаа	46,768,334	31,725,864	29,239,163	22,649,747 1,433,788 131,816,896
Бусад актив-бусад авлага	1,458,863	255,773	-	- 1,714,636
	<b>162,767,134</b>	<b>48,982,291</b>	<b>31,681,163</b>	<b>22,649,747</b> 1,470,834 <b>267,551,169</b>
<b>Пассив</b>				
Харилцагчдын харилцах, хадгаламж	202,222,289	14,878,467	15,630,461	106,339 - 232,837,556
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	7,435,989	-	-	- 7,435,989
Монголбанкнаас авсан зээл	251,201	71,000	498,900	197,000 - 1,018,101
Засгийн газрын зээл	-	500,000	-	- 500,000
Гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас авсан зээл	400,065	620,448	634,753	3,139,541 1,799,551 6,594,358
Бусад пассив	4,386,536	453	-	- 4,386,989
	<b>214,696,080</b>	<b>16,070,368</b>	<b>16,764,114</b>	<b>3,442,880</b> 1,799,551 <b>252,772,993</b>
<b>Цэвэр позиц</b>	<b>(51,928,946)</b>	<b>32,911,923</b>	<b>14,917,049</b>	<b>19,206,867</b> (328,717) <b>14,778,176</b>
<b>Зөрүү</b>	<b>(51,928,946)</b>	<b>(19,017,023)</b>	<b>(4,099,974)</b>	<b>15,106,893</b> <b>14,778,176</b>

### Хүүгийн эрсдэл

Зах зээлд зонхилж буй хүүгийн хувийн хэлбэлзлээс үүдэн Банкны санхүүгийн байдал болон мөнгөн гүйлгээнд эрсдэл үүсдэг. Зах зээлийн хүүгийн өөрчлөлтийн борлуулалтын ашиг ба цэвэр орлогод үзүүлэх нөлөөллөөр хүүгийн эрсдлийг хэмждэг. Хүүгийн орлого авчирдаг активын төлөгдхөн хугацааны бүтэц пассивынхаас хэр ялгаатай байна тэр хэмжээгээр, мөн хүүгийн хөдөлгөөнөөс хамаарч цэвэр хүүгийн орлого ёсч, буурдаг. Банкны хүлээж байгаа дахин үнэлгээний болон эргэн төлөлтийн хугацаанууд нь гэрээнд заасан хугацаатай ойролцоо байдаг бөгөөд үүнийг өмнөх хуудсанд үзүүлсэн төлбөрийн чадварын эрсдлийн хүснэгтээс харна уу.

Банкны удирдлагаас тогтоосон хязгаарын хүрээнд позицийг нэмэгдүүлэх буюу бууруулах замаар хүүгийн эрсдлийг удирддаг. Эдгээр хязгаар нь ханшийн зөрүүгээс олох цэвэр ашиг болон хүүнд мэдрэмтгий актив, пассивын үнэ цэнэд үзүүлэх нөлөөг багасгаж байдаг.

Банкны хүүгийн хувь хэмжээний талаар баримталж буй бодлогыг Банкны актив пассивын удирдлагын хороо хяналж баталдаг. Банкны “Бодит үнийн ёсөлт, бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэхгүй” санхүүгийн мөнгөн хэрэгслүүдийн хүүгийн түвшинг 2006 болон 2005 оны байдлаар дор үзүүлэв:

## 25. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Хүүгийн эрсдэл (үргэлжлэл)

	2006		2005	
	Гадаад		Гадаад	
	Төгрөг	Валют	Төгрөг	Валют
<b>Хүү олдог актив</b>				
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	4.25% - 8.00%	5.00% - 10.80%	4.25% - 8.00%	8.00%
Монголбанкны үнэт цаас	1.91% - 9.55%	-	1.91% - 9.55%	-
Авлагын бичиг	-	12.00%	19.20%	12.00%
Зээл ба урьдчилгаа	6.00% - 42.00%	12.00% - 26.40%	6.00% - 42.00%	12.00% - 26.40%
<b>Хүү төлдөг пассив</b>				
Харилцах данс	1.20% - 3.60%	1.20%	1.20% - 3.60%	1.20%
Хугацаатай хадгаламж	7.56 % - 18.60%	3.96% - 8.40%	12.00% - 17.40%	6.00% - 8.16%
Хугацаагүй хадгаламж	7.20%	3.60%	7.20%	3.60%
Төсвийн байгууллагын харилцах, хадгаламж	4.50%	-	4.50%	-
Бусад харилцах, хадгаламж	7.20% - 16.80%	3.60% - 8.40%	7.20% - 17.40%	3.60% - 8.16%
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадагаламж	3.60% - 12.0%	5.0% - 9.0%	3.00% - 4.80%	3.00% - 4.00%
Монголбанкаас авсан зээл	10.00%	-	10.00%	-
Засгийн газрын зээл	6.00%	-	6.00%	-
Гадаад, дотоодын санхүүгийн байгууллагаас авсан зээл	7.46% - 15.96%	2.00% - 8.87%	7.92% - 15.96%	2.00% - 7.63%

## 26. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Бодь Интернейшнл ХХК нь Банкны дүрмийн санг 100% эзэмшдэг.

Бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад зээл олгох, хадгаламж байршуулах, гадаад валютын гүйвуулгын гүйлгээ хийх зэрэг холбоотой талуудтай хэд хэдэн гүйлгээ хийсэн байна. Эдгээр ажил гүйлгээг арилжааны нөхцлөөр зах зээлийн ханшаар гүйцэтгэсэн.

Банкинд томоохон санхүүгийн сонирхол бүхий холбоотой талуудтай тухайн жилд хийсэн гүйлгээний хэмжээг, 12 сарын 31-нээрх үлдэгдлээр дор үзүүлэв:

	2006	2005
	мян. төг	мян. төг
a) Холбоотой компаниудад олгосон зээл ба урьдчилгаа	215,285	-

Холбоотой компаниудад олгосон зээл нь барьцаатай байсан. Зээлүүд нь жилийн 14.4% -18.0% хүү тооцдог ба эргэн төлөгдхөг хугацаа нь нэг жилийн дотор дуусна. Тайлант жилд тус зээлүүдээс хүлээн авсан хүүгийн орлого нь 2.11 сая төгрөг байна.

	2006	2005
	мян. төг	мян. төг
б) Холбоотой талуудаас хүлээн авсан харилцах, хадгаламж:		
Толгой компани	164,076	9,160
Холбоотой компаниуд	1,736,941	3,150,457
	<b>1,901,017</b>	<b>3,159,617</b>

Дээрх холбоотой талуудын байршуулсан харилцах, хадгаламж нь жилийн 3.00% - 13.20% (2005 онд 3.00% - 13.20%) хув тооцдог. Тайлант жилд эдгээр холбоотой талуудад төлсөн хүүгийн зардал нь 72.74 сая (2005 онд 54.40 сая) байсан.

	2006 мян. төг	2005 мян. төг
в) Холбоотой компаниудаас худалдан авсан компьютер, программ хангамж:	206,003	302,585
г) Гаражийн түрээс	1,268	1,672

д) Бодь Интернэйшнл ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээ

2002 оны 11 дүгээр сард Банк нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбайн 3-т байршилтай өөрийн шинэ ажлын байранд нүүн орсон. Энэ барилгыг Банкны толгой компани болох Бодь Интернэйшнль ХХК эзэмшдэг. Банк нь 2008 он хүртэл 6 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулсан. Банк нь 3.2 тэрбум төгрөгийн түрээсийн төлбөрийг 2003 онд урьдчилж төлсөн. 2006 оны 12-р сарын 31-ний байдлаар урьдчилсан төлбөрийн дүн нь 1,094 сая (2005: 1,619 сая) төгрөг байна. Тус түрээсийн хугацаа дусахад, Банк байраа үргэлжлүүлэн түрээслэх боломжтой.

	2006 мян. төг	2005 мян. төг
е) Гол удирдах албан тушаалтуудад олгосон нөхөн олговор		
Цалин	59,907	44,687
Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	11,382	8,491
	<b>71,289</b>	<b>53,178</b>

## 27. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ХЭЛЦЭЛ

Банк түрээслэгчийн хувьд төрөл бүрийн байрны үйл ажиллагааны түрээсийн гэрээ (цуцлах нөхцөлтэй)-нд тал болсон байна. Эдгээр гэрээг цуцалсан тохиолдолд Банк түрээслүүлэгчид нэг сарын өмнө мэдэгдэх үүрэгтэй. Эдгээр гэрээнд түрээсийн хугацааг сунгах, түрээслэж буй байрыг худалдан авах ба түрээсийн үнэ ханш нь түрээсийн хугацааны турш нэмэгдэх боломжтой талаар заалтууд байхгүй болно.

## 28. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 5%, эрсдлээр жигнэсэн хөрөнгийн харьцааг 10% байхаар тогтоосон байдаг бөгөөд ингэхдээ нийт хөрөнгө болон нийт активыг эрсдлээр нь жигнэж тооцдог. 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тус Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг үзүүлбэл:

	2006 мян. төг	2005 мян. төг
Өөрийн хөрөнгийн харьцаа	14.58%	12.27%
Эрсдлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	16.68%	12.27%
I зэрэглэлийн хөрөнгө	2006 мян. төг	2005 мян. төг
Дурмийн сан	21,934,142	13,434,142
Хуримтлагдсан ашиг	9,359,924	6,840,382
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	<b>31,294,066</b>	<b>20,274,524</b>
II зэрэглэлийн хөрөнгө		
Хоёрдогч еглөг	4,500,000	-
Нийт суурь хөрөнгө	<b>35,794,066</b>	<b>20,274,524</b>

## 28. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрсдлээр нь жигнэсэн активуудыг эрсдлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

%	2006		2005	
	Эрсдлээр		Эрсдлээр	
	Актив	жигнэсэн	Актив	жигнэсэн
мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг
0	54,346,543	-	47,201,919	-
10	-	-	-	-
20	111,911,673	22,382,335	85,386,487	17,077,297
50	1,623,042	811,521	68,123	34,062
100	191,441,790	191,441,790	148,106,171	148,106,171
<b>Total</b>	<b>359,323,048</b>	<b>2 14,635,646</b>	<b>280,762,700</b>	<b>165,217,530</b>

## 29. САНХҮҮГИЙН ҮҮРЭГ

<b>Батлагдсан, гэрээ байгуулсан:</b>	2006		2005	
	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг
Үндсэн хөрөнгө			317,751	106,227

## 30. САНХҮҮГИЙН ҮҮРЭГ БА ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ЗҮЙЛС

- a) Санхүүгийн үүргүүд ба балансын гадуурх зүйлс

Банк нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад харилцагчиддаа хууль зүйн тусlamж үзүүлэх үүрэг хүлээдэг. Эдгээр гүйлгээнүүдийн үр дүнд ямар нэгэн материаллаг алдагдал хүлээнэ гэж үзэхгүй байна.

	2006		2005	
	мян. төг	мян. төг	мян. төг	мян. төг
Баталгаа ба аккредитив		5,882,277		17,874,510
Балансын гадуурх бусад зүйлс		1,044,269		259,102
	<b>6,926,546</b>		<b>18,133,612</b>	

- b) Гадаад валютын арилжааны үүрэг ба дериватив

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны хүрээнд Банк нь гадаад валютын арилжааны гэрээг гуравдагч талтай байгуулдаг. 2006 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкинд (2005 онд нээлттэй позици байгаагүй) гадаад валют арилжааны форвард гэрээнүүд дээр нээлттэй позици байхгүй байсан.

- b) Балансын гадуурх бусад зүйлс .

2006 ба 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар балансын гадуурх бусад зүйлсд данснаас хассан чанаргүй зээл ба зогсоосон хүү багтсан болно.

### **31. ХАРЬЦУУЛСАН ТООН ҮЗҮҮЛЭЛТ**

Тайлант жилийн толилуулгад нийцүүлэхийн тулд дор үзүүлсэний дагуу дахин ангилсан 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зарим нэг дүнгүүдийг эс тооцвол тайлант жилийн санхүүгийн тайлангуудын толилуулга ба ангилал нь өмнөх тайлант жилийнхтэй адил байна. Үүнд:

	<b>Өмнө илэрхийлснээр мян. төг</b>	<b>Дахин илэрхийлснээр мян. төг</b>
<b>Тайлан тэнцэл</b>		
Үндсэн хөрөнгө	3,197,814	(120,337) 3,077,477
Биет бус хөрөнгө	-	120,337 120,337
<b>Орлого, үр дүнгийн тайлан</b>		
Хүүгийн бус орлого	4,941,371	(1,200) 4,940,171
Үйл ажиллагааны зардал	(5,142,799)	1,200 (5,141,599)

### **32. САНХҮҮГИЙН АКТИВ, ПАССИВЫН БОДИТ ҮНЭ**

Санхүүгийн хэрэгслүүд нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдээс бүрддэг. Санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ гэдэг нь уг хэрэгслийн талаар мэдлэгтэй, сонирхож буй талуудын хооронд аливаа нэг хөнгөлөлтгүйгээр (үүнд дампуурлын эсвэл албадан борлуулалт хамаарахгүй) санхүүгийн хэрэгсэл арилжаалагдаж чадах дүн юм. Энд зах зээлийн нэрлэсэн үнэгүй нехцөлд бодит үнэ цэнийг хөрөнгө, өр төлбөрийн хугацаа болон чанарыг харьцуулан хямдруулсан хувиар хэмждэг.

2006 ба 2005 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн хэрэгслийн ихэнхи хэсэг нь шинж чанарын хувьд 1 жил хүртэлх төлбөрийн хугацаа бүхий богино хугацаат хэрэгслүүд байна. Нэмж тодруулахад, ижил төстэй санхүүгийн хэрэгслийн өнөөгийн зах зээлийн хүү нь Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөх үеийн үр ашигт хүгээс томоохон зөрүүгүй байна. Дээрх бодит үнийн үнэлгээнд үндэслэн, эдгээр богино ба урт хугацаат санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн тайлан тэнцлийн өдрөөрх тооцоолсон бодит үнэ нь тэдгээрийн тайланда тусгасан бүйгээ бүртгэлийн дүнтэй ойр байна.

### **33. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Монгол хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хоорондын зөрүү ялгаа гарах тохиолдолд Англи хувийг дагах болно.

